

09 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

**а/ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** “Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийг тохиолдуулан аймгийн ИТХ-ын дарга Д.Хосбаяр болон Баруун-Урт сумын ИТХ-ын дарга Т.Ихбаяр болон холбогдох албаны хүмүүс МУ-ын ерөнхий сайд асан Ц.Жигжиджавын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүллээ. Сүхбаатар аймгийн хэмжээнд 2000 гаруй хүн байдаг. Үүнээс 40 гаруй иргэнд нийт 1 тэрбум 420 сая төгрөгийн дэмжлэг үзүүлжээ.

Баруун-Урт сумын ИТХ болон цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгээс 10-12-р ангийн ЕБС-ийн сурагчдын дунд “Хэлмэгдүүлэлтийн хар шуурга” нэртэй эссэ бичлэгийн уралдааныг тогтмол зохион байгуулж шалгарсан сурагчдад шагналыг гардуулж өглөө. Мөн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр тэдний үр хүүхэдтэй хамтран Эрдэнэмандал хийдэд 1000 зул өргөж буян үйлдэх ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус VI дугаар хуралдаан 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 14.00 цагт аймгийн Нутгийн удирдлагын ордны хурлын танхимд цахим болон танхимаар хуралдав. Энэ удаагийн хуралдаанаар Аймгийн хэмжээнд 2022 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт тогтоох тухай асуудлыг хэлэлцлээ. 2022 онд аймгийн хэмжээний 13 суманд 1156 иргэнд 106.2 га газар өмчлүүлэхээр тогтоолын төсөл батлагдлаа. Энэхүү тогтоолыг МУ-ын Засгийн газарт өргөн барьж засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн батлагдсны дараа 2022 онд иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах юм. Мөн хуралдаанд аймгийн ИТХ-ын төлөөлөгч, аймгийн Засаг даргын орлогч Д.Шижирбаатар санал оруулснаар аймгийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гоц халдварт үхрийн арьс товруутах өвчний талаарх цаг үеийн мэдээллийг мал эмнэлэгийн газраас хийв.

**б/ Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:**

Монгол Улс Азийн Хөгжлийн Банк (АХБ)-нд гишүүнээр элссэний 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан бүсчилсэн зөвлөлдөх уулзалтад зүүн бүсийн бусад аймгийн хамт оролцож, АХБ-наас санхүүжүүлсэн төслүүдийн үр нөлөө, сургамжийн талаар аймгийн Засаг даргын орлогч Г.Мөнхзаяа танилцуулга хийсний зэрэгцээ хэлэлцүүлгийн үеэр орон нутгийн хөгжлийн зорилтууд, тулгамдсан асуудлуудын талаар мэдээлэл хийж, санал солилцлоо.

Мобиком корпорацийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэцагаан- Бичигтийн боомт хүртэлх 75 км газар шилэн кабель оруулах ажил хийгдэж байна. Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Мобикомын ерөнхий захирал Тацүяа Хамада болон гүйцэтгэх захирал холбогдох хүмүүс ажлын явцтай газар дээр нь очиж танилцлаа. Уг ажил 700 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа юм.

Аймгийн ИТХ-ын дарга Д.Хосбаяр, аймгийн Засаг дарга М.Идэрбат нар аймагт хийгдэж буй томоохон бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцлаа. Шинэ наадмын талбайн барилгын бүтээн байгуулалтын ажил эхлээд явж байна. Суурь цутгалтын ажилд шаардлагатай байгаа цементны асуудлыг ИТХ-ын дарга Д.Хосбаяр шийдвэрлэж өгсөнөөр ажил хэвийн үргэлжлэхээр болсон юм.

Баруун-Урт сумын 2,4, 5-р тойргийн авто замын бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцлаа. Ажил хэвийн үргэлжилж байна.

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 2021 оны 3 дугаар улирлын байдлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайланг нэгтгэн дээд шатны байгууллагад хүргүүлжээ.

Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад 8754 өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний 8533 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 97.3 хувийн үзүүлэлттэй байна. Хугацаа болоогүй 221 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна.

Аймгийн хэмжээний нийт төрийн захиргааны байгууллагад хандаж гаргасан өргөдлийг агуулгаар нь ангилахад Нийгмийн даатгал, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст хандаж гарсан иргэний өргөдөл, хүсэлт зонхилж байна.

2021 оны 3-р улирлын байдлаар Аймгийн Засаг даргад хандаж 33 өргөдөл бичгээр болон Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвөөр дамжин ирсэн байна.

**Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал**

/2021 оны 3 дугаар улирлын байдлаар/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	Шийдвэрлэлтийн хувь
1	Аймгийн ЗДТГ	33	28	-	-	5	<b>84.8</b>
2	Агентлаг	5536	5503	-	-	33	<b>99.4</b>
3	Сумд	3185	3002	-	-	183	<b>94.2</b>
	<b>ДҮН</b>	<b>8754</b>	<b>8533</b>	-	-	<b>221</b>	<b>97.4</b>

**Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:**

2021 оны 09 дугаар сарын байдлаар Улсын төсөвт 2561.3 сая төгрөг төвлөрүүлэх 2828.5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 110.4 хувиар, Орон нутгийн төсөвт 7418.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 9476.4 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 127.7 хувиар тус тус биелэж нийт төлөвлөгөө 9980.2 сая.төгрөг төвлөрүүлэхээс 12304.9 сая.төгрөг төвлөрүүлж 123.3 хувиар биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 4851,9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 35919,9 сая төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулж ирсэн.

**Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн талаар:** ОНХСангийн орлогын шилжүүлэг төлөвлөгөө 8181,8 сая.төгрөг үүнээс гүйцэтгэлээр 9560,2 сая.төгрөг шилжиж ирсэн. Үүнээс сумдад олгох хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг өссөн дүнгээр 3172,1 сая.төгрөг , аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудын гүйцэтгэл санхүүжилт 4717,5 сая.төгрөг, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хувь 42,8%-тай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж буй 16 төсөл арга хэмжээнээс 2021 оны төсвийн жилд санхүүжих дүн 11701,6 сая. төгрөг, үүнээс гүйцэтгэлээр 5794,3 сая.төгрөгийн санхүүжилт олгогдож 49,5%-тай байна. Ковид-19 нөхцөл байдалтай уялдаж гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах, 2021онд санхүүжих батлагдсан санхүүжилтийг бүрэн авч хөрөнгө оруулалтын үр дүнг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

**Татварын хэлтэс:** Эхний хагас жилд 2020 оны хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд олгосон мөнгөн урамшууллыг судалгааны дагуу 4968 иргэнийг 01010104 татварын төрлөөр бүртгэж, суутгасан татварын “Урьдчилгаа төлбөрийн нэхэмжлэх” үүсгэн 19638,0 татварын орлогыг бүртгэж, сум, дүүргийн төсвийн орлогын гүйцэтгэлд орууллаа.

Мөн 736 иргэний ХХОАТ-ын буцаан олголтыг ТУНС-д бүртгэсэн. Урьдчилгаа нэхэмжлэх үүсгээгүй гүйлгээ хийгдсэн малын албан татварыг урьдчилгаа нэхэмжлэх үүсгэж ТУНС бүртгэсэн.

**Өмчийн бүртгэл, хяналтын чиглэлээр:** 09 дүгээр сард 49,032,143 сая төгрөгийн үнэ бүхий 2 эд хөрөнгө /Онгон сумын сум дундын эмнэлэг, Бичиг- Их өргөө ОНӨААТҮГ/ -ийг Онгон сумын ЗДТГ, Сүхбаатар тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-уудад шилжүүлж өгсөн. Мөн 6,325,347 төгрөгийн балансын үнэтэй Наран сумын ЗДТГ-ын хуучин барилгыг 4,890,208 төгрөгөөр хоёрдогч түүхий эдээр худалдахыг зөвшөөрсөн тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гаргуулсан байна.

Мөн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд Дарьганга сумын Дарьганга тохижилт –Үйлчилгээ ОНӨААТҮГ-т худалдан авсан ОХУ-д үйлдвэрлэсэн усан халаалтын тогоог тус байгууллага нь ашиглахгүй болсон тул Баяндэлгэр сумын ЕБС-д бүртгэж, эзэмшүүлэх тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гарч, хяналтад авч ажиллаж байна.

Энэ сард 10 байгууллагаас эд хөрөнгө худалдах, актлах, худалдан авах санал хүсэлт, албан тоот ирсэн бөгөөд 3 байгууллагын санал хүсэлтийг аймгийн ИТХ-н тэргүүлэгчдийн шийдвэр гаргуулж, мөн газрын даргын зөвшөөрлийн дагуу хариуг хүргүүлж ажилласан.

**Худалдан авах ажиллагааны хүрээнд:** “2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу 2021 оны 09 дүгээр сард tender.gov.mn сайтаар дамжуулан нийт давхцсан тоогоор 9 бараа, ажил, үйлчилгээний тендерийг зарлаад байна. Үүнээс 09 дүгээр сард гэрээ байгуулсан 1, дахин зарласан 2 тендерт тус бүр 2 удаа, үнэлгээг хийгдээгүй байгаа 0, хүлээн авах хугацаа нь болоогүй байгаа 7 тендер байна.

09 дүгээр сард нийт 1 бараа, ажил, үйлчилгээний тендерийн үнэлгээг хийж, захиалагч байгууллагад зөвлөмж /98,830,039 төгрөг/ хүргүүлсэн байна. Хэмнэлт 1,169,961 төгрөг байна.

**Хяналт шалгалтын чиглэлээр:** Баруун-Урт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар болон сангуудад санхүүгийн хяналт шалгалт, Уулбаян сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвд дотоод аудитын тус тус хийгдэж байна. Асгат сумын ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв болон сангуудад санхүүгийн хяналт шалгалт хийгдээд дууссан байна. Шалгалтаар нийт 37983.0 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс 8 салбар актаар 21701.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, илэрсэн зөрчилд 2998.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага өгч ажиллалаа.

#### **Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:**

**Боловсрол, Соёл урлагийн чиглэлээр:** 08 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Элсэлтийн Ерөнхий шалгалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 529 шалгуулагч шалгалтад орсон.

БСУГ-ын зөвлөн туслах баг БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан А/525 түр журмын хэрэгжилт, хичээл сургалтын үйл ажиллагааны бэлтгэл, зохион байгуулалттай танилцах зорилгоор Асгат, Халзан, Уулбаян, Түвшинширээ, Мөнххаан сумд, аймгийн төвийн 4 сургууль, 11 цэцэрлэгт ажилласан.

Сургууль цэцэрлэгийн хамран сургах тойргийг тогтоож, элсэлт бүртгэлийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж, аймгийн төвийн сургуулиудад шилжиж ирсэн 40 сурагчийг хуваарилсан. Мөн бүртгэлд хамрагдаж чадаагүй 6 настай 30, 7 настай 16 хүүхдийг 1-р ангид нэмж оруулсан.

Сургуулийн өмнөх байгууллагад зайн болон танхимын сургалтад 2195 хүүхэд суралцаж хамрагдалт 85,8 хувь байна. Танхимын сургалт-49,7% зайн сургалт-33,9% Өвчтэй - 62 хүүхэд байгаагаас ковидоор өвдсөн 15 Чөлөөтэй 286 хүүхдээс ойрын хавьтал болж тусгаарлалтад 171 хүүхэд байна.

Ерөнхий боловсролын 16 сургууль, 24 цэцэрлэг, дотуур байр, НТБТөв, БСУГ-ын нийт 1402 албан хаагч Ковидын -19 халдвараас сэргийлэх 3 дахь тун вакцинд хамрагдах хүсэлт ирүүлснээс 9-р сарын 28-ны өдрийн байдлаар 16 сургууль, НТБТ, НДБ, БСУГ-ын нийт 544 / 60.2%/ , 24 цэцэрлэгийн 397 / 79.7%/, нийт 941 / 67.1%/ албан хаагч хамрагдаад байна.

“Сүхбаатар – Нэг мөрөөдөл” ТББ –аас зарласан “ Шилдэг багш” шалгаруулах уралдааны 2-р шатны шагнал гардуулах үйл ажиллагаа зохион байгуулагдаж аймгийн хэмжээнд 25 багш тус бүр 3 сая төгрөгөөр шагнагдсан.

БСШУЯ, Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулж буй “Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх судалгаа”- хийх арга зүйн сургалтад БСУГ-ын мэргэжилтнүүд хамрагдаж сонгогдсон 10 сургуулийн бага ангийн багш нар болон дуу хөгжим биеийн тамирын багш нарт сургалт явуулж, арга зүй удирдлагаар хангаж ажилласан.

БШУсайдын А/280 дугаар тушаалаар батлагдсан “Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлэх журам”- ын дагуу захирлын тушаалаар сургууль тус бүр дээр ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг томуугийн эсрэг вакцинжуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн 8130 сурагч вакцин хийлгэх хүсэлт ирүүлснээс 4806 суралцагч 59.1%, цэцэрлэг 3699 хүүхэд хүсэлт ирүүлснээс 1524 хүүхэд 41.2% хамрагдсан байна.

Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулсан “Ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлага, хэрэглэгдэхүүний жагсаалт боловсруулах” ажлын үр дүн хэлэлцүүлэгт 16 сургуулийн захирал 32 багш оролцсон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Ази тивийн сүүний түншлэлийн Нарийн бичгийн дарга нарын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон Олон улсын сүүний холбоотой хамтран “Dairy Asia webinar: School Milk Program” сэдэвт бүс нутгийн цахим арга хэмжээнд БСУГ-ын мэргэжилтнүүд, ЕБС-ийн захирлууд оролцсон.

БШУЯ-ны Тусгай хэрэгцээт боловсролын хэлтсийн мэргэжилнүүдтэй хамтран Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд “Хүүхэд хөгжлийн танхимын нээлт” - ийг хийж, тус багийн бүрэлдэхүүн 1-р сургууль, 11-р цэцэрлэг, НТБ төвийн үйл ажиллагаатай танилцан, тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдтэй ажиллах зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилласан.

БМТТ /Боловсролын мэдээлэл технологийн төв/-өөс зохион байгуулсан “Ээлжит хичээлийн цахим контентын бүрдүүлэх үйл ажиллагаа”- ны талаар мэдээлэл өгөх уулзалтад ЕБС-ийн захирал, БСУГ-ын мэргэжилтнүүд оролцсон.

Дэлхийн багш нарын өдөр, Монгол улсад боловсролын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг угтан Монгол Улсын засгийн газрын болон, БШУЯ-ны шагналын болзол хангасан нийт 119 багш ажилтны материалыг уламжлан хүргэсэн.

Боловсролын салбарт үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй “Би багш” арга хэмжээний удирдамжийг багш нарт яаралтай хүргүүлж, оролцох хүсэлтэй багш нарыг дэмжиж, оролцох боломжоор ханган, зохион байгуулалтыг хийж ажилласан.

БШУЯ-наас зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сургалтад бага ангийн багш нар болон БСУГ-ын мэргэжилтэн оролцсон.

Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан салбарын шагналаар шагнуулахаар 14 хүний материалыг хүргүүлэн, шагналыг хүлээн авч гардууллаа.

Улсын төвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 4-р цэцэрлэгийн их засвар, 5-р сургуулийн барилгын ажлын явцтай танилцаж, үүрэг чиглэл өгсөн.

**Хөгжимт жүжгийн театр:** Соёл урлагийн ажилтны өдрийг угтан орон нутгийн BBS телевизтэй хамтран уран бүтээлийн дуу, хөгжим, драм, бүжиг ангиудын тус тус бүрийн ярилцлага авч телевиз болон байгууллагын цахим хуудсаар олон нийтэд хүргэсэн.

Ая зохиогч, Жаахан шарга театрын хөгжимчин МУСТА Б.Тэгшжаргалын “Амьдрал...” цомгийн нээлтийг 9-р сарын 19-нд “Жаахан шарга” театрт хийсэн. Нээлтийг орон нутгийн BBS телеюиз шууд дамжуулан үзэгч олонд хүргэсэн.

“Өвлөгдсөн Монгол” төслийн багийнхантай хамтран 9 сарын 22-нд Шаргын ууланд Л.Цэдэвсүрэнгийн “Дарьганга магтаал”-ын клипний зураг авалтыг хийсэн.

Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан Засгийн газрын шагналаар 3, аймаг, орон нутгийн шагналаар 6 уран бүтээлч тус тус шагнагдсан байна.

**Угсаатны зүйн музей:** Харуул хамгаалалт, дохиолол хамгаалалтын чиглэлээр хийгдсэн ажлын тайланг Соёлын яам болон аймгийн боловсрол соёлын газарт хүргүүлсэн.

Насан туршийн боловсрол төвийн сургагч багштай холбогдож цахим “GOOGLE–MEET” ашиглан монгол бичгийн сургалтыг 7 хоногийн давтамжтайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Түвшинширээ сумын соёлын төвийн БМСанчид сан хөмрөг дэх үзмэр, эд өлгий зүйлийг бүртгэн баримтжуулах талаар арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.

Гэмт хэрэг зөрчил гарсан үед хэрэгжүүлэх журмыг сан хөмрөгч, аймгийн бүртгэл мэдээллийн санч нар боловсрууллаа.

Хонгорын голын хүн чулууны талаар эрдэм шинжилгээний судалгаатай мэдээлэл бэлтгэн байууллагын цахи хуулсанд байршуулсан.

Сан хөмрөгт хадгалагдаж байгаа эх сурвалжгүй гэрэл зургуудын эх сурвалжийг тодруулан бүртгэн баримтжуулах зорилгоор Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей цахим хуудсанд байршуулан цувралаар баримтат өвийн эргэн сурвалжлах ажлыг зохион байгуулж байна.

Сан хөмрөгт 2020 онд Эрдэнэмандал хийдээс хүлээж авсан 25 дэсийн 25 ширхэг үзмэр, “Дарьганга өв мөнгөн цом” Гачуурт ХХК-н Чинбатын хандиваар худалдан авсан Дархан М.Балдан-Осорын мөнгөн аяга, Археологийн хүрээлэнгээс хүлээж авсан 59-н дэсийн 132 ширхэг нийт 86 дэсийн 159 ширхэг үзмэрийг “RCH” ‘программд бүртгэж дууссан.

**Нийтийн номын сан:** “Номын баяр-2021” арга хэмжээг угтаж шинэ ирсэн ном болон шилдэг ном, зохиол, номын тухай, ном уншихын ач холбогдол, уншсан номоо хэрхэн тэмдэглэл хөтлөх, номын талаарх сонин хачин мэдээлэл, хүүхэд залуусын заавал унших номын тухай зэрэг мэдээллийг тогтмол хүргэн сурталчилж байна.

“Нутгийн найраг” булангаар Сүхбаатар аймгаас төрөн гарсан зохиолч, уран бүтээлчдийн зохиол бүтээлээс “Найргийн хур” булангаар монголын зохиолчдын зохиол бүтээлээс “Уран зохиолын цаг” шилдэг өгүүллэг туужийг цувралаар хүргэн сурталчилж байна.

Монгол улсад орчин үеийн номын сан үүсгэн байгуулагдсны 100 жилийн ойн хүрээнд Үндэсний тогтмол хэвлэлийн мэдээллийн цахим сан гэж байгуулж байгаатай холбогдуулан 2000 оноос өмнөх орон нутгийн сонин дээр гарсан бүх материалыг уг санд оруулах ажил хийгдэж байна.

**Биеийн тамир, спортын газар:** Сүхбаатар аймгийн усан спортын сургалтын төвд 2021.09.18-19-ны өдрүүдэд “Дэлхийн аварга” шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулах сорилго тэмцээн амжилттай болж 7 клубын 52 тамирчин өрсөлдсөн.

Монгол улсын рекордыг “Орчлон” клубын тамирчин Энххүслэн өврөөр даллах сэлэлтээр шинэчлэн тогтоосон. Мөн дэд мастерын болзол хангасан.

2021 оны 09 дүгээр сарын 20-26-ны өдрүүдэд Азийн хөл бөмбөгийн холбооны “В” зэрэглэлийн дасгалжуулагч бэлтгэх сургалтанд хөлбөмбөгийн дасгалжуулагч Ц.Өсөхбаяр хамрагдсан.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг тус хэлтсийн байранд болон цахимаар зохион байгууллаа. Уг сургалтад төрийн болон төрийн бус байгууллага, ААН байгууллагын ХАБ-ын ажилтан болон ажилчдын ҮЭ-ийн хорооны төлөөлөл болох 120 гаруй хүнийг хамрууллаа.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны "Хяналт шалгалтын аян зохион байгуулах тухай" А/120 дугаар тушаал, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын А/106 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын 2021.09.06-ны А/529 дугаар захирамжаар Засаг даргын орлогч Г.Мөнхзаяагаар ахлуулсан Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжэ, хугацааг даатгуулагчид тогтоосон байдалд хяналт хийх ажлын хэсэг байгуулагдаж хяналт, шалгалтыг явуулж байна.

Асгат сумын нийгмийн даатгалын байцаагч Дөхөм багийн иргэдийн нийтийн хуралд оролцож нийгмийн даатгалын хууль, сайн дурын даатгал, МХХЭ-ийн ажилласан жилийг нөхөн тооцох тухай хуулийн сурталчилгаа хийж иргэдийн асуусан асуултад хариулж, 137 иргэнд тараах материал тараан ажиллалаа.

Дарьганга сумын байцаагч 1, 2, 4 багийн айлуудаар тойрч нийгмийн даатгалын хууль, сайн дурын даатгал, МХХЭ-ийн ажилласан жилийг нөхөн тооцох тухай хуулийг сурталчлан таниуллаа.

**Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны талаар:** 09-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 655 иргэнээс эмэгтэй 294, бүртгэлтэй ажилгүй иргэн 496 иргэнээс, эмэгтэй 216 иргэн байна. Аж ахуй нэгж байгууллагаас 434 ажлын байрны захиалга бүртгэгдэж 359 иргэнийг ажилд зуучилсан байна. Үүнээс: Эмэгтэй 192 иргэн зуучлагдсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 212 буюу 59 хувь нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 254 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн.

Аймгийн хэмжээнд ХЗЗ-ийн судалгааг 2021 оны 9 дүгээр сарын 15-наас 2 сарын хугацаатай зохион байгуулж байна. Судалгаагаар орон нутагт шаардлагатай байгаа мэргэжил, мэргэжилтэй ажилтан ажлын байрны мэдээллийг салбар бүрээр нь гаргаж байна.

“Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох төслийг 21 хоногийн хугацаатай зарлаж хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт 6 сумын 9 төсөл, 35 аас дээш насны санхүүгийн дэмжлэгт 6 сумын 12 төсөл хүлээн авсан.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх-Оролцоо” төслийн сургалтад 85 залуу хамрагдаж эхний ээлжийн 80 залууг 14 хоногийн дадлага хийлгэхээр аж ахуйн нэгжүүдэд хувиарласан. Цаашид дээрх залуучуудыг өөрсдийнх нь өгсөн захиалгын дагуу мэргэжил олгох сургалт болон байнгын ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулж байна. Төсөлд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн 29 залуу хамрагдсан.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь мэргэжлийн хяналтын газартай хамтран Монгол Жү Фань Ли, Говьмастер, Сунхунголд, Шинэ –Интернэшнл, Кензроуд, Бадмаараг хаш, Андын-Илч, Их урсгал, Хунт-Өгөөж, Монголын цахилгаан холбоо, Каскейдмайнинг, Цайрт минерил, Эм Эл Цахиурт Овоо, Дорнын чулуулаг, Дорноос мандах туяа, Хөндлөн хайрхан, Мэдээлэл холбоо, Алаг тогоо нийт 18 аж ахуй нэгж байгууллагуудад цалин хөлсний үзлэг шалгалтыг хийж илүү цагийн хөлс дутуу олгосон 1 аж ахуйн нэгжид 1686967 төгрөгийн нөхөн төлбөр, ЗТХуулиар 1500000 төгрөгийн торгууль, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгосон 1 аж ахуй нэгжид 3392000 төгрөгийн акт тогтоож улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж цаашид дүрэм журмаа мөрдөн ажиллах зөвлөмжийг өгч ажилласан.

Эндээ хөгжил” ХХК-аас зохион байгуулсан ХАБЭА-н болон ҮОМШӨ тухай 2 өдрийн сургалтанд 25 байгууллагын ХАБЭА-н ажилтан, цэцэрлэгийн эрхлэгч нарыг танхимаар болон цахимаар хамруулсан.

**Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:** 09-р сард 6 сумын 17 иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, 26 иргэний ахмадын хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийн 13 хувийн хэргийг хүлээн авч нийгмийн халамжийн Waic программд баталгаажуулсан. E-halamj прорграммд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийн 4, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн 47, жирэмсэн эхийн 18, ихэр хүүхдийн тэтгэмж 1, онцгой тохиолдлын тэтгэмжийн 1, өрх толгойлсон эхийн тэтгэмжийн 1 үйлчилгээг хүлээн авч хянан баталгаажуулсан. Сумдын мэргэжилтнүүдээс тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт тусламж авах 42 иргэний жагсаалтыг баталгаажуулан авч / WAIS, E-halamj / программд баталгаажуулан нөхөн олголт хийсэн.

2021 оны 09 дүгээр сард олгох 1953 иргэний 192,784,790 мянган төгрөгийн тэтгэмж, 38 иргэний 7202,4 мян. төгрөгийн ахмадын хөнгөлөлт, 178 иргэний 5793,7 мян.төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийн жагсаалтыг тулган хаан банк, төрийн банкуу илгээсэн. “E-halamj” цахим системээр олгогдох 1237 иргэний 350091,2 мян.төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон ахмад настны тэтгэврийн, 534 иргэний 20066,6 мян.төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж, 3231 иргэний 158773,0 мян.төгрөгийн 0-3 хүртэлх

насны хүүхэд асарсны тэтгэмж, 2 иргэний ихэр хүүхдийн тэтгэмж, 4 иргэний онцгой тохиолдлын жагсаалтыг тулган баталгаажуулж төрийн сан илгээсэн.

Халамжаас-Хөдөлмөрт уриан дор Баруун-Урт сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авагч өрхөөс хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, ажил хөдөлмөр эрхлээгүй 209 иргэний судалгааг гаргаж ажил зуучлах үйлчилгээнд хамруулж байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхүүдэд хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлж байгаа гэрээт 18 хүнсний дэлгүүрт НӨАТ баримт олгодог дурын дэлгүүрээс өрх хүнсний бүтээгдэхүүнээ авдаг болох бэлтгэл ажлын хүрээнд касс программын хөгжүүлэлтийг холбогдох газруудаар хийлгэж 9 дүгээр сараас шинэ программаар олголт хийгдэх мэдээллийг утсаар болон цахимаар өгч ажилласан. Касс програмын хөгжүүлэлтийг 14 гэрээт хүнсний дэлгүүр хийсэн байна.

Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дах заалтын дагуу ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллагагүй нийт 3820 ахмадад 3820,0 мянган төгрөгийн хүндэтгэлийг “Олон улсын ахмадын өдөр”-г тохиолдуулан харилцах дансаар олгосон.

Улаанбаатар хотын “Алсын оч оптик” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, Халзан, Баяндэлгэр, Дарьганга, Наран, Онгон сумдын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 249 хүний хараанд тохируулан нүдний шил хийлгэж төрийн үйлчилгээг газар дээр хүргэж ажилласан.

Аймгийн ахмадын хороотой хамтран ажиллах гэрээ байгуулж Баруун-Урт, Мөнххаан, Баяндэлгэр, Асгат, Халзан сумдын нийт 100 ахмадад 9000,0 мянган төгрөгийн өдрийн үйлчилгээг үзүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 09 сард 2 удаа хуралдаж 15 хүүхэд орсноос 5 хүүхэд асаргаанд шинээр хамрагдаж, 10 хүүхэд асаргаа сунгагдсан байна.

Монгол Улс дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төслийн хүрээнд "Монгол улс дахь ажлын байранд дадлагажуулагчийн анхдугаар сургалт" болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан Биенийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын тухай ойлголт (ICF), ХБИОХҮС төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудын талаар цахим сургалтанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссын 7 гишүүн хамрагдсан.

Мөн ХНХЯам нийгмийн ажилтны холбоотой хамтран “Нийгмийн ажлын үйлчилгээ, мэргэжлийн удирдлага” хэлэлцүүлэгт 9 албан хаагч хамрагдаж мэдлэг, мэдээлэл авч ажилласан.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт”-ын мэдрэлийн өвчний заалтуудтай холбоотой асуудлаар болон уналт, таталттай хүүхдүүдийн байнга ууж хэрэглэдэг эм, тариа, дархлааны бэлдмэлүүдтэй холбоотой асуудлаарх цахим уулзалтанд 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр хамрагдсан.

### **Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр:**

**Хууль, эрх зүй:** Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын гишүүний зөвлөмжийн хариуг хүргүүлсэн.

**Цагдаагийн газар:** Аймгийн Шуурхай штабын “Тандалт судалгааны баг”-т тус газрын 1 алба хаагч ажиллаж, батлагдсан тохиолдлуудын ойрын хавьтал 159 иргэний судалгааг гарган, явсан маршрут, хаяг байршлыг тогтоон “Хариу арга хэмжээний баг”-т шилжүүлсэн ба цаашид хавьтал тогтоох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна.

Хүн амын дунд коронавируст халдвар голомтлон тархаж буй энэ үед байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 8 бүлэг, 93 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Тус цагдаагийн газрын алба хаагчдаас цагдаагийн алба хаагч 46, олон нийтийн цагдаа 3, нийт 49 алба хаагч коронавирус /ковид 19/-ын халдвар авсан болох нь PCR

шинжилгээгээр батлагдан тусгаарлан эмчлэх байранд хэвтэн эмчлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 10 алба хаагч эмчлэгдэж байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, жолооч, зорчигч нарын хариуцлага, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг “Ирээдүйгээ хамгаалъя” уриатайгаар зохион байгуулж байгаатай холбогдуулан тус цагдаагийн газраас “Хичээл эхэллээ” хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулан “Ирээдүйгээ хамгаалъя” уриатай тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын тусгай дуут дохио бүхий авто машин, иргэдээс 10 авто машин, 10 мотоцикльтой цуваагаар Баруун-Урт сумын төвийн нэгдүгээр тойргийн замаар тойрч арга хэмжээний нээлтийг хийж иргэдэд сурталчилж, шторк бэлтгэн хандалт ихтэй 20 цахим хаягт байршуулж ажилласан.

Мөн хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан 09 дүгээр сарын 01-ний өдөр авто машинуудын гэрлийг асаалган “Гэрлээ асаасанд баярлалаа” зурагт самбар 5 ширхэгийг хийлгэн тодорхой цэгүүдэд байршуулж ажилласан. Дээрх арга хэмжээний хүрээнд хийсэн ажил арга хэмжээний талаар орон нутгийн BBS телевизээр мэдээлэл хийж, иргэд олон нийтэд сурталчилсан байна.

Амралт аяллын өдрүүдтэй холбоотойгоор “Үер усны аюул”, “Зам тээврийн осол”-оос урьдчилан сэргийлэх зорилгоор 4 төрлийн зурагт хуудас хийлгэн Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар пэйж хуудаст байршуулан 13 сумдын 25 группэд түгээн иргэдэд хүргэсэн. Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн 14 төрлийн шторкыг 14 сумын 40 группүүдэд түгээн иргэдэд хүргэсэн

Цагдаагийн газраас “Хичээл эхэллээ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн төвийн 4 сургуулийн “Эцэг эхийн зөвлөл”-үүдэд хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэрхэн хамтарч ажиллах, эцэг эхийн хараа хяналтыг сайжруулах, чиглэлээр цахимаар зааварчлага өгч “ХҮҮХЭД ЗОРЧИЖ БАЙНА” наалтыг цагдаагийн газрын алба хаагчдын болон иргэдийн тээврийн хэрэгсэлд 300 ширхгийг байршуулж ажилласан.

Мөн Ерөнхий боловсролын сургууль болон Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчдын дотуур байрны багш, нийгмийн ажилтнуудтай уулзаж, орой үдшийн цагаар дотуур байрны хүүхдүүдийг гадагш гаргахгүй байх, нэг бүрчлэн бүртгэж байх, сурагчдын дотуур байр болон байрны орчинд бусдыг дарамтлах, сүрдүүлэх, дээрэмдэх зэрэг гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажиллах талаар зөвлөмж өгч, дотуур байранд амьдардаг 250 орчим хүүхдүүдэд гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирох, холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр Зөрчлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хэсгийн байцаагч нартай хамтран сургалт зохион байгууллаа.

Цагдаагийн газраас Монгол Улсад орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн баярын хурал, хүндэтгэлийн цахим концертод хурлын танхимаас оролцох 6 хүндэт зочид, төлөөлөгчид, 56 алба хаагч, 12 ахмад ажилтны төлөөллийг халдвар хамгааллын дэглэм чанд сахиулж, хүн хоорондын зайг баримтлан оролцууллаа.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний 75 ялтан, этгээдүүдэд холбогдох материалд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан. Үүнд: Торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 14 ялтны 53400,0 төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 92 ялтны 7046,0 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, 104 ялтны 11481,0 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 2 ялтны 10450,0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын урьд оны үлдэгдэл 1 ялтны материал дээр шүүхээс шинээр ирсэн 6 ялтны 1636 цагийн ялын материалыг хүлээн авч, 1 ялтны 240 цагийг хорих ялаар солиулж, 7 ялтны 1784 цагийн ялын хугацаа дуусгавар болсон.

Эрх хасах ялын урьд оны 25 ялтны 11729 хоногийн үлдэгдэл дээр 16 ялтны 13633 хоногийн материал нэмэгдэж, 2 ялтны 3650 хоног үндсэн ялаа эдэлж дууссан үндэслэлээр нэмэгдэж, 19 ялтны 10837 цагийн ялыг дуусгавар болгож, үлдэгдэл 21 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны үлдэгдэл 5 этгээдийн 19764,0 төгрөг материал дээр шүүхээс шинээр 12 этгээдэд холбогдох 28039,5



төгрөгөөс 15 этгээдийн 24303.5 төгрөгийн хөрөнгө орлогын хураасан авч орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр 2021 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 110 хүн, хуулийн этгээдэд холбогдох 67332.7 төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 88 хүн хуулийн этгээдийн 36255.2 төгрөгийг бүрэн биелүүлж, 16 хүн хуулийн этгээдэд холбогдох 30520.0 төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд бодит биелэлт 76.1 хувьтай байна.

Монгол Улсын Өршөөлийн хуулиар суллагдаж зорчих эрхийг хязгаарлах ялаар солигдсон 20 этгээдэд тавьж ажилласнаас ялын хугацаа дуусгавар болсон 2, хяналтын хугацаанд зөрчил гаргаж ял сольсон 1, өнөөдрийн байдлаар 17 этгээдэд хяналт тавин ажиллаж байна.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр:** Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр нийт 554 гүйцэтгэх баримт бичгээс: төлбөрийн биелүүлбэл зохих 313 гүйцэтгэх баримт бичгийн 2438983.4 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж 102 гүйцэтгэх баримт бичгийн 913306.6 мянган төгрөгийн материалыг дуусгавар болгож, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 64.5 хувьтай байна. Бодит биелэлт урьд оны мөн үеэс 7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүүхдийн тэтгэлгийн 241 гүйцэтгэх баримт бичгийн 970632.7 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, хэсэгчлэн 185 гүйцэтгэх баримт бичгийн 327865.0 мянган төгрөгийг төлүүлж, 19 гүйцэтгэх баримт бичгийн 377221.4 мянган төгрөгийг дуусгавар болгон нийт 365087.4 мянган төгрөгийг биелүүлсэн ажилласан.

Үлдэгдэл 222 гүйцэтгэх хуудасны 593411.3 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байна.

Цагдан хорих байрны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, хоригдол, хоригдогчийн зүгээс гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бүхий л ажлыг биечлэн зохион байгуулан ажилласны үр дүнд орголт, гэмт хэрэг гаргаагүй ажиллаж байна.

Цагдан хорих байр нь 2012 оны 11 дүгээр сард ашиглалтад орж, бүтэц зохион байгуулалт нь стандарт шаардлагад нийцэхгүй, хорих өрөө, салхилуулах талбайд байгалийн гэрэл тусдаггүй, хоригдсон этгээдийн суурь, жам ёсны эрхийг зөрчиж байна гэж Хүний эрх, Прокурорын байгууллагаас удаа дараа зөвлөмж хүргүүлж байсан.

Үүний дагуу Төсвийн төвлөрүүлэн захирагчтай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дээрх ажлыг хэрэгжүүлэхээр тусгаж, энэ хүрээнд цагдан хорих байрны урд талд салхилуулах талбайг шинээр барьж, хуучин салхилуулах талбайг албан ажлын өрөө болгох ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийн явц 60 хувьтай хийгдэж байна. Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хоригдлын ахуй нөхцөлийг сайжруулах зорилгоор удаан хугацааны эргэлт, уулзалтын байрыг шинэчлэн засварлах тохижилтын ажлыг энэ ондоо багтаад дуусгахаар төлөвлөж байна.

**Шүүхийн шинжилгээний алба:** Албаны бие бүрэлдэхүүн цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнтэй хамтран хэргийн газрын үзлэгт 16 удаа оролцсноос хүний амь нас хохирсон хэргийн дуудлаганд 5, хулгайн хэргийн дуудлаганд 4 удаа, зам тээврийн осол хэргийн дуудлаганд 4, бусад дуудлаганд 3 удаа явж, хэргийн газрын үзлэгээр гарын мөр 1, тээврийн хэрэгслийн мөр 5 ширхэг, бусад ул мөр, эд мөрийн баримт 18 ширхэг, нийт 30 ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авсан байна.

8-р сарын байдлаар хэргийн газрын үзлэгийн 243 кадр, шинжилгээний 36 кадр, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 110 кадр, нийт 399 кадр гэрэл зургийг боловруулж, гэрэл зургийн үзүүлэлт хийж мөрдөгч нарт хүлээлгэн өгсөн.

Криминалистикийн шинжээч нар нь гарын мөрний 8 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2009 оны 110 дугаар тушаалаар батлагдсан “Гарын хээний нэгдсэн сангийн журам”-ын дагуу 947 иргэний гарын дардасыг авч Адис-Папилон санг баяжуулаад байна.

Тус албаны шинжээч эмч нар нь хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 35 удаа хийснээс хүнд 1, хүндэвтэр 2, хөнгөн 12, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 11, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй 9 дүгнэлт гаргасан байна. Бэлгийн маргаантай хэргийн үзлэг 1 хийж дүгнэлт гаргасан.

Гэмт хэргийн болон бусад шалтгаанаар нас барсан 5 цогцост шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.

Шинжээч эмч нар нь химийн 10 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна. Аймгийн Цагдаагийн газар баривчлагдсан, захиргааны зөрчил гаргасан 18 хүний гарын дардасыг живой скайнераар авч Адис-папилон ажлын станцыг баяжуулсан.

#### **Улсын бүртгэлийн хэлтэс:**

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл:** Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-319, анхны бүртгэл-35, өмчлөх эрх шилжих гэрээ-68, барьцааны гэрээ-193, бүртгэлд өөрчлөлт оруулах -6, лавлагаа хуулбар-0, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-108

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-200 анхны бүртгэл-10, өмчлөх эрх шилжих гэрээ-53, барьцааны гэрээ-13, бүртгэлд өөрчлөлт оруулах -9, лавлагаа хуулбар-1 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-72

**Хуулийн этгээдийн улсын бүртгэл:** 2021 оны 09 дүгээр сарын байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо- 19 Үүнээс ХК-0, ХХК-6, төрийн бус байгууллага-0, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -0, орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -0, Төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар-0, нөхөрлөл-0, хоршоо-0, хадгаламж зээлийн хоршоо-0, сан-0, үйлдвэрчний эвлэлийн байгууллага-0, шашны байгууллага-0, хэвлэл мэдээллийн байгууллага-0 бүртгэгдээд байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-0, татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-0, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-1, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт - 6, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналт лавлагаа олгосон -6, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг 0 –г тус тус бүртгэн хурааж авсан байна.

**Иргэний бүртгэл:** Иргэний бүртгэлийн тасаг нь 2021 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 140 төрөлт, гэрлэлт 63, гэрлэлт цуцлалт 7 үрчлэлт 7 эцэг тогтоолт 10 овог нэр өөрчлөлт 4, нас баралт 45 аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 135, үндэсний энгийн гадаад паспорт 17, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 94, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 1019 тус тус бүртгэгдэж олгосон байна.

#### **Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт**

**Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын чиглэлээр:** Газар зохион байгуулалт геодези зурагзүйн газраас хийгдсэн төлөвлөгөөт хяналт, шинжилгээ үнэлгээнд 2021 оны 09 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд шалгуулан холбогдох заавар зөвлөгөөг аван ажиллалаа.

Аймгийн хэмжээний 13 сумын бэлчээрийн газрын өөрчлөлтийн фотомониторингийн ажлын үр дүнг газрын кадастрын нэгдсэн системд оруулж үр дүнг нягтлан Газрын даамалгүй байгаа 2 сумын боловсруулалтын ажлыг холбогдох мэргэжилтэн гүйцэтгэж үр дүнг системрүү оруулан ажиллаж байна. Аймгийн хэмжээний тайланг нэгтгэн ГЗБГЗЗГ-т хүргүүлэхээр тайлан, зураглал үр дүнг нэгтгэн ажиллаж байна.

2022 онд 1156 иргэнд 106.2 га газар өмчлүүлэхээр төлөвлөж байна.

Газрын удирдлагын нэгдсэн системээр дамжуулан газар өмчлөх, эзэмших, ашиглах, барьцаалбартай холбоотой 77 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч 36 өмчлөл, эзэмшилийн газарт засаг даргын шийдвэр гаргуулан эрх зүйн харилцаа үүсгэж газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчтай гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хувийн хэрэг үүсгэн ажилласан байна.

Баяндэлгэр сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орсон нэгж талбаруудын эргэлтийн цэгийн тодорхойлох ажлаар тус суманд 2 хоног ажиллаж төлөвлөлтийн нийт 189 эргэлтийн цэгийг тодорхойлж, трасс татах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 1 дуудлага худалдааны газрын эргэлтийн цэгийг газарт буулгасан. Мөн Баруун-Урт сумын дунд-Урт-д байрлах тариалангийн талбайн хяналтын хэмжилт хийн нийт 20 цэгийн хэмжилт хийж, 6 тариалангийн талбайн зураглалын ажлыг хийж гүйцэтгэсэн. Баруун-Урт сумын шинэ наадмын талбайн газрыг төлөвлөлтийн дагуу газар дээр нь буулгаж ажилласан байна.

ГЦТ 5338 дээр GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын тасралтгүй хэвийн ажиллагааг ханган ажиллах ажлын хүрээнд 3-р улирлын хяналтын хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.

Багийн нэрийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд нийт 13 сумын 67 багийн тогтоолыг нэгтгэн аймгийн ИТХ-аар дэмжүүлэх тогтоолын төслийг бэлдэн хүргүүлсэн.

БХТөвийн инженерүүдийн хамт Баруун-Урт, сумын Цэвэрлэх байгууламжийн барилга, 5,5 болон 2 инженерийн шугам сүлжээний ажил, Мал эмнэлэгийн ариутгалын пункт 960 хүүхдийн сургуулийн барилгуудад угсралтын ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж заавар үүрэг даалгавар өгч ажиллалаа. Мөн Баяндэлгэр, Мөнххаан, Уулбаян Эрдэнэцагаан сумдуудад он дамжин буюу шинээр ажлууд нь эхэлж буй объектуудад хяналт хийж заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй шинээр хэрэгжиж буй барилга байгууламжид ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрөл 2 олгож, [urban.gov.mn](http://urban.gov.mn) сайтаар 2 зөвшөөрөл олгон ажиллаж байна.

Шинээр эхэлж буй барилгуудад 3 компанитай зохиогчийн хяналтын гэрээ байгуулан ажиллалаа.

Барилгын материалын, сорилт шинжилгээний лабораторит 3 шинжилгээ хийгдсэн байна. Бетон шоо 3 шинжилгээ хийн үр дүнг боловсруулан цаг тухай бүрт нь хариуг олгон ажиллаа.

13 Сумдын хэмжээнд төвийн төрийн байгууллагын барилга байгууламжийн мэдээллийг цаасан маягтаар 83 байгууламжийн мэдээллийг нэгтгэн авч ажиллаж байна.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм нормативыг мөрдүүлж ажиллах, ажлын зургийн хянан баталгаажуулалт хийх, заавар зөвлөмж дагуу 3 зургийн хянан баталгаажууллаа.

**Биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр:** Аймгийн хэмжээнд Ургамлын төрөл зүйл, тархац нөөцийн судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлэх тендрийг 6-р сард зохион байгуулж гүйцэтгэгчээр “Гарааны ногоон дэлхийн чанар” ХХК шалгарч дээрх ажлыг аймгийн нийт нутаг дэвсгэрт 8-р сарын 05-наас эхлэн 9-р сарын 05-ны хооронд судалгааны ажлыг хийж гүйцэтгээд одоогоор суурин буюу мэдээлэл боловсруулах тайлан мэдээллийг боловсруулж байна.

Аймгийн хэмжээнд Ерөнхий агнуур зохион байгуулалтын тендерт шалгарсан “Авралын эрэлд” ХХК-ны хээрийн судалгааны баг бүх сум болон хээрийн судалгааны маршрутын дагуу судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн Засаг дарга, БОАЖГ-ын дарга нарын байгуулсан гэрээний дагуу нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд Дарьганга суманд байрлах Нарт, Хишиг нэмэх, Янзаган хүрээ зэрэг нөхөрлөлүүдийн ажилтай газар дээр нь очиж танилцан Нарт нөхөрлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулан 2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлхээр шийдвэрлэсэн.

Аймгийн BBS тү-д мэдээ-3 удаа /Нэгдсэн хогийн цэгийн ойр орчмын 10 га газарт түрэлтийн ажил, Тамир био бэлдмэл, Сүхбаатар аймагт Эко 00 хэрэгжиж байгаа талаар/, шторк-5 /Хог хаягдлын тухай хууль, Хог хаягдал гэж юу вэ?, Хог хаягдлыг ангилах нь, Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлье, Ой, хээрийн түймэр/, уншдаг зар-2 /Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлье, Худаг гаргах зөвшөөрөл/ тус тус явуулж байна. БОАЖГ-ын фейсбүүк хуудсаар дамжуулан цаг үеийн болон 14 мэдээлэл оруулж 27156 хүний хандалт авсан байна.

Амьтны чиглэлээр:Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Наран, Онгон, Уулбаян сумдын Байгаль хамгаалагч нар БОАЖЯамны гаргасан зөвшөөрөл олгох тухай албан бичгийн дагуу тухайн орон нутагт идлэг шонхор барихаар явж байгаа иргэдэд хяналт тавин ажиллаж байна.

Наран суман дахь Монгол тарваганы тархац байршил, тоо толгойг гаргах зорилгоор сумын 1-р багийн нутаг болох Хайрханы ширээ, 2-р багийн нутаг болох Баяндулаан уул

орчмын нутагт тарваганы мониторинг судалгааг хийж өглөө оройн гарааг харсан. Нийт 15 дош байсан бөгөөд ойролцоогоор 8 тарч, 5 бурхи, 10 гаруй мөндөл байсан.

Усны нөөцийг хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр: Энэ онд БХНСАХ-ний санхүүжилтээр 5 булгийн эхийг хашиж хамгаалах ажил хийгдэнэ. 9/27-ны байдлаар Дарьганга сумын 4-р багт байрлах Салаа булгийн эхийг хашиж хамгаалаад байна.

Түвшинширээ сумын Өгөөмөр багийн нутаг Годил гэх газар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн зориулалтын гүн өрмийн худаг гаргах ажлыг “Голден хилл” ХХК гүйцэтгэж хүлээлгэн өглөө.

Хог хаягдлын чиглэлээр: Баяндэлгэр сумын ИТХ Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтын дагуу “Хог хаягдлын үйлчилгээний хураамж” тогтоож ИТХ-д санал оруулах ажлын хүрээнд иргэдээс санал авах ажлыг цахим хэлбэрээр явуулж байна.

Наран суманд өрхийн амьжиргааны түвшин доогуур 3 иргэнээр сумын төвийн зам дагуух, тоглоомын талбай, Ж.Батсуурийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн зэрэг газрын хог хаягдлыг цэвэрлүүлж ажиллалаа. Нийт 5 га газраас 101 кг хог хаягдлыг цэвэрлүүлсэн. Мөн Асгат суманд Нийтийн эзэмшлийн газар болон төв гудамжны хөл газрын 3 тн хогийг түүж цэвэрлүүлсэн байна.

**Газрын хэвлий, ТХГН, уул уурхайн талаар:** Мөнххаан сумын 5-р багийн нутаг болох Бүрэнцогт уул уурхайн эвдэрсэн газарт 1 га-д нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэхээр аймгийн ажлын хэсэг ирж газартай нь танилцаж “Эм эл Цахиур овоо” ХХК-аар хийлгэсэн.

**Эрчим хүчний чиглэлээр:** Халзан сумын АТП№64 дэд станц, Сүхбаатар сумын 2км 0.4кВ-ын АШ шинээр татах, АТП№35 дэд станц байрлалыг өөрчилсөн. Түвшинширээ сумын АТП№40 дэд станцын 800м АС шугамын СИП болгон шинэчилж, 15кВ-ын АШ-д Наран суманд 191ш Дарьганга суманд 540ш Мөнххаан суманд 200ш Талбулагийн 10кВ-ын АШ-д 160ш шувууны хамгаалалт суурилуулж АШ-ын засварын ажил хийгдсэн

**Уул уурхайн салбарт:** Аймгийн Засаг даргын 2021 оны А/519 дүгээр захирамжаар “Бадмаараг хаш”, “Эрдэнийн босго” ХХК-иудын нүүрс, жонш тээвэрлэлтийн чиглэл түр тогтоосон хугацааг 2021 оны 11 дүгээр сарын 30-ныг дуустал сунгасан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/521 дүгээр захирамжаар Наран сумын Хонгор нэртэй талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг “Теллюс” ХХК-д 3 жилийн хугацаагаар олгосон.

УУХҮЯ, Мерит төслөөс зохион байгуулсан уул уурхайн салбарын бодлого, хэрэгжилтийн талаарх мэдээлэл солилцох цахим уулзалт, Газрын тосны тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой хэлэлцүүлэгт орон нутгаас оролцож орон нутагт тулгамдаж байгаа асуудал, холбогдох саналыг өгч ажилласан.

“Их бага баян шарга” ТББ байгууллагаас Баян шарга уулыг улсын тусгай хамгаалалтад авах ажлын талаарх танилцуулга уулзалтад аймгийн удирдлага, холбогдох хэлтэс, агентлагийн төлөөллүүд оролцож цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний талаар санал солилцсон.

**Зам тээврийн салбарт:** 2019-2021 онд улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа аймгийн төвийн 4 дүгээр тойргийн 9,1 км авто зам, 5 дугаар тойргийн 5,65 км авто зам, Баруун-Урт сумын 1-р багт баригдах 3,03км хатуу хучилттай авто зам, замын байгууламж, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдах аймгийн төвийн 2 дугаар тойргийн хатуу хучилттай авто замын засвар, шинэчлэлтийн ажлуудын ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

Баруун-Урт сумын 1, 3-р багт хийгдэх авто замын дагуух явган зам, гэрэлтүүлгийн ажлуудын гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

Баруун-Урт сумын 1-р баг нийтийн эзэмшлийн орон сууцнуудын гаднах зам талбайн ажлын явцтай танилцан Захиалагч, зураг төслийн зохиогч, гүйцэтгэгч байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж тулгамдаж байгаа асуудлыг газар дээр нь ярилцан шийдвэрлэн ажиллаж байна.

Авто зам, замын байгууламжаас авто зогсоол гаргах хүсэлт ирүүлсэн 2 аж ахуй нэгж, 2 иргэний өргөдлийг аймгийн засаг даргын А/627 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулан холбогдох зөвшөөрлийг олгосон.

### **Зургаа. Батлан хамгаалах**

Сүхбаатар аймгийн цэргийн штабын сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл шатны сургалтыг хээрийн байрлалд 8 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай зохион байгууллаа. Тус сургалтаар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдэд зэвсэг, техник дээр ажиллах дадлага, чадвар эзэмшүүлэх, Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн хэргийн мэдлэг, ур чадвар олгохыг зорьсон байна. Хээрийн байрлалыг Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн буудлагын талбай, материаллаг баазыг түшиглэн "Цэргийн дүрэм", "Цэргийн алба зохион байгуулах заавар"-ын дагуу эрүүл ахуй, хөдөлмөр аюулгүй байдлын стандарт шаардлагад нийцүүлэн төхөөрөмжилж явуулсан бөгөөд Сүхбаатар аймгийн прокурорын газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газраас мэргэжилтнүүдийг урьж дадлага сургалт, зохион байгуулсан.

1945 оны Чөлөөлөх дайны ахмад дайчин, "Төрийн хүндэт харуул"-ын дарга, БХЯ-ны нэгдүгээр орлогч сайд бөгөөд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цэргийн Ерөнхий дээд сургуулийн захирал, БХЯ-ны Сургалт эрхэлсэн анхны орлогч сайд, БНМАУ-ын БХЯ-ны сайд зэрэг нэр хүндтэй, хариуцлагатай албан тушаалуудыг хашиж, олноо "Рапорт Ёндон" хэмээн хүндлэгдсэн, хурандаа генерал Жамсрангийн Ёндон агсаны алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний хөшөө, дурсгалын цогцолборын нээлтийг хийлээ. Нээлтийн арга хэмжээнд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны сайдаар ажилласан, чөлөөнд байгаа дэслэгч генерал Л.Моломжамц, Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Ёндон генералын хүү Ё.Ганзориг, охин Ё.Наранцэцэг болон аймгийн удирдлагууд холбогдох албаны хүмүүс оролцов.

Энэхүү хөшөө, дурсгалын цогцолборыг бүтээн байгуулсанаар Хурандаа генерал Ж.Ёндон агсаны алдар гавьяа, дайчин замнал, үйл хэргийг алдаршуулан мөнхжүүлэх, хүүхэд залуучуудад сурталчлан таниулах, Монгол Улсын Зэвсэгт хүчний хөгжил, цэцэглэлтийн түүхийг олон нийтэд сурталчлах, ард иргэдийн чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх нөхцөл бүрдэж буй юм.

Батлан хамгаалах салбар төдийгүй ард олныхоо хайр хүндлэлийг хүлээсэн түүхэн их хүмүүний хөшөө, дурсгалын цогцолборыг бүтээн байгуулах ажлыг санаачилсан, дэмжиж тусалсан, гар бие оролцсон үр хүүхэд, Сүхбаатарчууд болон байгууллага, хамт олон хувь хүмүүст Батлан хамгаалахын Г.Сайханбаяр хөшөө дурсгалын цогцолборыг нээх үеэр талархал илэрхийллээ.

Аймгийн Засаг даргын 2021 А/548 дугаар захирамжаар 2021 оны ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн урьдчилсан үзлэг явагдах хуваарийг баталж, уг ажлыг эхлүүлээд байна.

### **Долоо.Шадар сайдын эрхлэх хүрээний агентлагууд**

#### **Онцгой байдлын газар:**

**Хяналт шалгалтын чиглэлээр:** Монгол Улсын Шадар Сайдын баталсан Боловсролын байгууллагуудад хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн болон бусад хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг нийт 32 албан байгууллага, аж ахуй нэгжид зохион байгуулж, нийт 204 зөрчил илрүүлэн шалгалтын хугацаанд 173 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 10-н заавал биелүүлэх албан шаардлага, 3 мэдэгдэл, 2 танилцуулга бичиж хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Сар бүрийн гамшгийн мэдээ, шифрийн мэдээг Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газарт, Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны 12 сарын 30-ны өдрийн 1/2834 тоот албан үүрэг, Монгол Улсын Шадар Сайдын баталсан Эрчим хүч, дулаан хангамжийн салбарын тогтвортой үйл ажиллагаа аж ахуй нэгж, байгууллага айл өрхийн гал түймрийн аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн арга хэмжээний явцын тайланг Онцгой

байдлын ерөнхий газарт, Сарын 15,30-ны өдөр хялбаршуулсан журмаар захиргааны шийтгэл ногдуулсан мэдээг аймгийн Прокурорын газарт тус тус явуулсан.

Аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу 5 аж ахуй нэгж, байгууллагуудад ажлын байрны дүгнэлт гаргаж 12505 төгрөг, 1 барилгын зураг хянаж 50000 төгрөг, нийт 62505 төгрөгийг аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлэн ажиллалаа.

**Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар:** Эрчим хүч, дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагаа, аж ахуйн нэгж, байгууллага, гэр хорооллын 2810 иргэдэд гал түймрийн аюулгүй байдлыг хангуулж пийшин зуухны аюулгүй ажиллагаа, малын өвс тэжээл хураалттай айл өрхүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч холбогдох гарын авлага бүхий постер зурагт хуудас 1580 ширхгийг тарааж ухуулга сурталчилгааг зохион байгуулан ажилласан. Гал түймрийн шалтгаан нөхцөл иргэдийн болгоомжгүй байдал, зориулалтын бус цахилгааны утасны ашиглалт, цахилгаан хэлхээний хэт ачаалал зэрэг хувь хүний санамсар болгоомжгүй байдлаас үүдэн гарах эрсдэлийн талаар холбогдох мэргэжилтнүүд орон нутгийн BBS телевизээр сэрэмжүүлэг зөвлөмж хүргэсэн. Онцгой байдлын газар болон УЦУОШТ-өөс Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээг орон нутгийн BBS-телевизээр 70 удаагийн давтамжтай ард иргэдэд хүргэж ажилласан. Урьдчилан сэргийлэх чиглэлийн ажил арга хэмжээний явцыг баримтжуулан иргэдэд мэдээлэл хүргэх зорилго бүхий “Сүхбаатар онцгой байдлын газар” facefook хаягаар дамжуулан давхардсан тоогоор 12.310 орчим иргэд хандалт авч ажилласан байна. Үер усны аюулаас сэргийлье, Коронавирусээс сэргийлье урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг su.nema.gov.mn цахим сайт, Сүхбаатар Онцгой байдлын газар facebook хаягт аюулаас урьдчилан сэргийлэх, шторк, бичлэгийг орон нутгийн телевизээр 10 удаагийн давтамжтайгаар 290 удаа нэвтрүүлж, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх 3 мэдээлэл бэлтгэн Сүхбаатар аймгийн 5 сайтад байршуулан иргэдэд сурталчилгааны ажлыг хүргэлээ.

“Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”, “Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны нийтлэг заавар”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ковид-19 халдвараас сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэгийг хүн ам ихээр цуглардаг гудамж талбайд зорчиж байгаа иргэдэд амны хаалтыг тогтмол зүүх, байгууллага аж ахуй нэгжээр үйлчлүүлэхдээ хүн хоорондын зай барих талаар зарлан мэдээллийг, тусгай дуут дохиот бүхий тээврийн хэрэгсэлтэйгээр зохион байгуулсан. Гал түймэр унтраах аврах 15,47 дугаар ангийн бие бүрэлдэхүүн иргэдэд сэрэмжлүүлэг хүргэн хүн хоорондын зай барих, амны хаалтаа зүүж үйлчлүүлж байгаа болон халдвар хамгаалалтын дэглэм бариулан ажиллаж байна. Нийт 25-н зөрчил дутагдал илэрснээс ангилж үзвэл. Үүнд:

- Ил задгай үнс нурмаа асгасан-5
- Цахилгаан мантож зөрчилтэй-8
- Пийшин зуухны аманд галд тэсвэртэй хамгаалалт байхгүй-5
- Ил задгай өвс хадгалалт, хамгаалалт-7

Аймгийн Онцгой комиссын 25 дугаар хуралдаан, Шуурхай штабын тохиолдлын удирдлагын тогтолцооны баг бүлгүүд өдөр болгоны 10:00 цагт хуралдаж, мэдээлэл солилцон тулгамдсан асуудлыг шийдэж, УОК-ын 42, 43, 46 дугаар тушаалаар баталсан журмыг удирдлагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ажлын хүрээнд, Коронавируст халдварт “КОВИД-19”-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журмыг хэрэгжүүлэх төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэм сахиулах, ажил үйлчилгээг хэвийн явуулах тусгай нөхцөл шаардлага, нийтлэг журмуудыг аж ахуйн нэгж байгууллагуудад мөрдүүлж ажиллах талаар Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газартай хамтран хяналт шалгалт зохион байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Иргэдэд зориулсан коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх тусгай нөхцөл шаардлага бүхий зурагт хуудсыг 2512 ширхгийг хэвлэн аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн самбар болон орох, гарах, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим зэрэгт нааж ухуулга сурталчилгааг зохион байгуулсан.

Үер, усны аюулаас сэрэмжилье, Дотоодын нөөц хангах зорилгоор 6 нэр төрлийн хүнсний ногоо тариалав, ОБГ-ын урд талбайн тусгай зориулалтын автомашинуудад нийцсэн

даац, стандартын 240 м2 замын цутгалтын ажлыг ГТУА 15 дугаар ангийн алба хаагчид хийж гүйцэтгэв, Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгууллаа,

“Ковид-19”-аас урьдчилан сэргийлэх, “Зай барь”, “ Ахуйн хүрээний гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлье”, “Үнс нурам”, “Объектын гал түймрээс урьдчилан сэргийлье”, “Мухар гудамж алслагдсан айл өрх”, Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг, Шалган нэвтрүүлэх пост болон Усан хангамж, Худалдаа үйлчилгээний газруудаар 3 төрлийн боршурийг нийт 2810 хүнд Гал түймэр унтраах аврах 15 дугаар анги, Эрэн хайх аврах салбарын алба хаагчид хамтарсан ухуулга сурталчилгааг зохион байгуулан ажилласан.

Баруун-Урт сумын хэмжээнд Гамшгаас хамгаалах дайчилгааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг томилон Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу аймгийн хэмжээнд 58 аж ахуйн нэгж байгууллагын Коронавирус "COVID-19"-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, цар тахалтай тэмцэх хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд мэргэжлийн ангийг дайчлах, хүн хүч, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж бэлэн байдлын үзлэгт 18 мэргэжлийн ангийн 110 техник хэрэгсэл, 263 хүн хамрагдсан байна. Аймгийн Онцгой комиссын 25 дугаар хуралдаан, Шуурхай штабын тохиолдлын удирдлагын тогтолцооны баг бүлгүүд өдөр болгоны 10:00 цагт хуралдаж, мэдээлэл солилцон тулгамдсан асуудлыг шийдэж, УОК-ын 42, 43, 46 дугаар тушаалаар баталсан журмыг удирдлагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээний чиглэлээр:** Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу “Кило майн” ХХК Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт байрлах Хүрэн нүүрсний “Алаг тогоо” ордын ил уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хийсэн гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланд анхан шатны шинжилгээ хийж ажилласан.

Аймгийн зудын эрсдэлийн үнэлгээг 13 сумыг хамруулан Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан хээрийн түймрийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу аймгийн Онцгой байдлын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Статистикийн хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, сумдын Засаг даргын Тамгын газар, Авто тээврийн төв, Эрүүл мэндийн газар зэрэг байгууллагын бодит мэдээлэлд суурилан хийж гүйцэтгэсэн.

**Гал түймэртэй тэмцэх, унтраах үйл ажиллагааны чиглэлээр:** Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэмжээнд 2021 оны 09 дугаар сард объектын гал түймрийн дуудлагаар 2-н удаа унтраах, аврах ажлыг зохион байгуулж, ард иргэдийн 20 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, тактикийн алдаа дутагдалгүй, техникийн сааталгүй ажилласан.

Д/д	Огноо /Цаг минут/	Гал гарсан газар /хаяг, овог нэр, юу шатсан/	Ус	Хөөс	Шатахуун	Аварсан Хөрөнгө /төгрөгөөр/	Хохирол /төгрөгөөр/
2	2021 оны 09 дугаар сарын 06 - ний өдөр	Түмэнцогт сумын Баян Овоо багийн 10 дугаар байшин шатаж байна.	28 тн	,	160 л		
Нийт			28 тн		160 л		

### Найм. Сумдад зохион байгуулагдсан ажил

#### **Баруун-урт:**

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, тус Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, чадамжийг сайжруулахын тулд Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 стандартыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд гол анхаарал хандуулан ажилласан. Стандартын 4 дүгээр үе шат болох Хэрэгжүүлэлт хэсгээр

байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг тодорхойлж SWOT шинжилгээг байгууллага дээрээ хийж гүйцэтгээд байна. Төслийн багт 18 албан хаагч хамрагдаж байгаа бөгөөд 4 удаагийн цахим хичээл, 4 удаа цахим зөвлөгөө, 3 удаагийн даалгаврыг хийж гүйцэтгээд байна.

Төрийн үйлчилгээний оператораас 62-н төрлийн үйлчилгээ лавлагааг иргэдэд түргэн шуурхай үйлчилсэн байна.

**Ногоон байгууламж, дэд бүтэц, хог хаягдлын чиглэлээр:** 2021 оны төлөвлөгөөний дагуу хийгдэх, дэд бүтэц, газар зохион байгуулалтын ажлууд хийгдэж байгаа бөгөөд Захирагчийн албаны зүгээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Нийт 9 байршилд камержуулалт хийж, хяналтын цэгт холбох ажлыг ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Баруун-Урт сумын 2-р багийн нутаг дэвсгэр Саруул хотхоны дунд камержуулах ажлын Талын технологи ХХКомпаниар хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

- 1-р багийн нутаг дэвсгэр Мандал хорооллын хуучнаар механикжуулалтын байрны 19-н айл өрхийг газар чөлөөлтөд хамруулан гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын явц 60 хувь.
- Монгол улсын иргэн газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн хүрээд Баруун-Урт сумын 9-р багийн зүүн талд 200 иргэнд газар өмчлүүлэх ажлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5,9-р багийн дунд баригдах зөөврийн усан сан барих, 4-р багийн жишиг хашаа барих ажлын тендерийг хууль тогтоомжийн дагуу зарлаад байна.
- Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Баруун-Урт сумын 8-р багаар ажлын хэсэг явц зөвлөмж хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Золбин нохой устгах ажлын хүрээнд Сүхбаатар тохижил ОНӨААТҮГ хамтран 18 нохойг устгах ажлыг хийж гүйцэтгүүлсэн.
- Багийн нутаг дэвсгэр дээрх их хэмжээний борооны ус тогтдог газруудад багийн Засаг нартай хамтран шороо асгаж тэгшүүлэх ажлыг 9-н байршилд хийж гүйцэтгэсэн.
- Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар сумын 6-н багийн нутаг дэвсгэрт 84 ширхэг цамхагт гэрэлтүүлэг байршуулах ажлыг “Уртын гэгээ” ОНӨААТҮГ хийж гүйцэтгээд байна.
- Аймгийн төвийн хэсгүүдэд 200 ширхэг лед гэрэл байршуулах ажлыг “Уртын гэгээ” ОНӨААТҮГ газар 80 хувьтай хийж гүйцэтгэж байна.
- 7-р багийн нутаг дэвсгэр 48-н айлын гадна нийтийн эзэмшлийн барилга байгууламжийн гадна дулаалга хөөсөн пассат хийх ажлыг Ёст бэйс ХХКомпани гүйцэтгэж байгаа ба хяналт тавих ажлыг хийж гүйцэтгэж байна.
- 7-р багийн нутаг дэвсгэр 27а, 27б, 36а, 36б байрны нийтийн эзэмшлийн орон сууцны дээвэр засварлах ажлыг Хайлааст гарам ХХКомпани шалгаран хийж гүйцэтгэж байгаа ба ажлын явц 60 хувьтай гүйцэтгэж байна.

**Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр:** Сумын хэмжээнд 16 га талбайгаас 15.4 тн хүнсний ногоо хурааж аваад байна.

Үхрийн арьс товруутах гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж 39 өрхийн 3023 үхэр, 1125 тугалд тус бүр үзлэг хийж вакцинжуулсан. 15 өрхийн хашаа, хороо, бэлчээрийн 20800 мкв талбайд ариутгал хийж, 40 үхрээс арьс товруутах өвчний 80 дээж авч Нийслэлийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.

**Коронавирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд:** Вакцинжуулалтын нэмэлт 3- дахь тунгийн нэг цэгийг ажиллуулж мэдээг өдөр бүр гаргаж тайлагнаж байна. Бруун-Урт сумын хэмжээнд 18-дээш насны иргэд 3-р тунд 30 % хамрагдаад байна. Хамрагдалтын хувь бага байгаатай холбогдуулан албан хаагчид вакцинд хамрагдах иргэдийн нэрсийг хуваарилан авч утасаар холбогдон хувийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.



### **Баяндэлгэр:**

**ЕБСургууль:** 2021-2022 оны хичээлийн жилд БШУСайдын А\88 дугаар тушаалаар батлагдсан боловсролыг нөхөн олгох сургалтын хөтөлбөрийг багш нар цахимаар судлан хэрэгжүүлж байна. Багш, ажилтан, сурагчид QR код уншуулан ирц бүртгэл хийгдэж байна.

"Smart Education" төслийн хүрээнд mobicom Корпорацаас зохион явуулж буй "УХААЛАГ БОЛОВСРОЛ" сэдэвт шилдэг бүтээлийг шалгаруулах уралдааны дагуу зорилтот бүлгийн 7 сурагч бүтээлээ явуулснаас 3 сурагч шагналт байранд шалгарав. Сургуулийн орчны анги танхимд голомтын ариутгал хийгдсэн.

**Соёлын төв:** Улсын төсвийн 1.988 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдах 300 хүний суудалтай шинэ соёлын төвийн барилгын ажлыг WORKMASTER ХХК гүйцэтгэхээр 2021.09.13-ны өдөр ажлаа эхлүүлсэн.

**Байгаль орчин:** Сумын ИТХ нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт татварын Ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтын дагуу "Хог хаягдлын үйлчилгээний хураамж" тогтоох тул ИТХ-д санал оруулахаар иргэдийн дунд "Хог хаягдлын үйлчилгээний хураамж" тогтоох санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж байна.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** СХС-ийн зээлийн эргэн төлөлт 4,3 сая төгрөг, зээлийн муу ангилалд шилжсэн 13 зээлдэгчийн 79,0 сая төгрөгийн зээлийн материалыг аймгийн прокурорын газарт хүргүүлсэн.

2020-2021 онд Улсын хөрөнгө оруулалтаар 3-р багийн Алтад, Далайн говь, 6-р багийн төв гэсэн 3 байршилд "Голден Хилл " ХХК гүн өрмийн цооног өрөмдөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Тухайн 3 худгийн холбогдох материал болон эзэмшигч 3 иргэний мэдээллийг аймгийн ХХААГ-ын бэлчээр, усан хангамж хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.

Сумын аюулгүй нөөцөд 20.0 тн өвс, 30 тн тэжээлийн нөөцтэй байна.

"Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай" Сумын засаг даргын А/56 захирамжийн дагуу малын эмч нар болон малчдад заавар зөвөлгөө өгсний дагуу энэ ажилд татан оролцуулж дотор, гадна шимэгчийг устгах зорилгоор мал сүргийг угаалганд бод-8270 бог-130887 мал хамрагдаад байна.

"Том ноёд" ХХК-нь улсын төсвийн хөрөнгөөр 4 багт мал угаалгын ванныг барих ажлыг эхлүүлэн одоогийн байдлаар 4-р багт барьж хүлээлгэн өгсөн.

Сумын бүх охин тугал ,хурга, ишигэнд Сумын засаг даргын А/98 тоот захирамжийн дагуу Бруцеллээс өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийгдэж, Тугал -5012, хурга - 66540, ишиг-32748 нийт -104300 төл хамрагдан цахим системд тулгалт хийгдэж байна.

Сүхбаатар аймгийн мал эмнэлгийн газраас Галзуу-10000 тун, Боом-13 л Дуут- 17 л вакцинуудыг татан авч таван аж ахуй нэгжүүдэд падаанаар хувиарлан олгож цахим системд төлөвлөгөөг оруулж өгсөн.

Аймгийн засаг даргын А/509 тоот захирамжийг үндэслэн Сумын засаг даргын 2021 оны 09 сарын 20-ны өдрийн А/113 тоот "Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хяналт тавих тухай" захирамжийн дагуу арга хэмжээ авч ажиллаж байна.

Аймгийн засаг даргын А/444 тоот, Сумын засаг даргын 2021 оны 09 сарын 21-ны өдрийн А/115 тоот "Мал сүрэгт шинжилгээ хийх тухай " захирамжийн дагуу сумын бүх хээлтүүлэгч малд бруцеллээс өвчний шинжилгээний тандалтын цус авахаар 2 ажлын хэсэг гарч ажиллаж байна.

### **Дарьганга:**

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 2021\_09\_27 ноос эхлэн сумын 4 багийн Иргэдийн нийтийн хурлын нарийн бичгийн дарга, тэргүүлэгчид, багийн Засаг дарга нарыг сонгох хурлыг зохион байгуулахаар шийдвэрлээд ажиллаж байна.

Сумын ВЭБ сайтыг гэрээний дагуу сайтыг хүлээн авч, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 07 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа бөгөөд төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 66 сая төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтаар (Одкон ХХК) –өөр нэгдсэн халаалтын 2 зуухыг ажиллуулаад халаалт өгөхөд бэлэн болсон.

Ковид-19 цар тахлын нөхцөлд сумын ЭМТ-тэй хамтран ажиллаж сумын Засаг даргын нөөцөөс 12,067160 (арван хоёр сая жаран долоон мянга нэг зуун жаран) төгрөгийг зарцуулж ажиллав.

Шинэ суурьшлын бүсэд 0,4 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөлийн зураг төсөлд 2 сая төгрөгийн санхүүжилтийг ОНХС-аас зарцууллаа.

Сумын төвийн ундны усны 2 худагт цэвэршүүлэх төхөөрөмжийг 19 сая төгрөгийн санхүүжилтийг ОНХС-аас шийдвэрлэн суурилуулсан.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** МУЗГ-ын Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай 221 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 07 тоот албан даалгаврын дагуу төв суурингийн болон хөдөө аж ахуйн өвөлжилтийн төлөвлөгөөг гарган батлуулж, төлөвлөгөөний дагуу тус суманд өвөлжих малын тоог урьдчилсан байдлаар 252225 толгой мал өвөлжүүлэх урьдчилсан тооцоог гаргаад байна.

Мал сүргийг ээмэгжүүлэх бүртгэлжүүлэх ажлын хүрээнд цөм сүрэг хуц, ухна болон хил дагуух нутаглаж байгаа малчдын үхэр сүргийг ээмэглэх бэлтгэл ажлыг хийгээд байна. Үүнд малын ээмэгний захиалгыг “Тэргүүн сүрэг” ХХК-тай гэрээ байгуулан мөнгийг шилжүүлээд байна.

Суманд хадлангийн 10 салаа гарч өвс бэлтгэх ажлыг хийж, одоогоор өвс 4000 тн бэлтгэсэн мэдээтэй байна. Сумын нөөц өвс бэлтгэх ажилд ЗДТГ-ын ажилчид гарч нөөцийн 2000 боодол өвс бэлтгээд байна.

Тус сумын иргэдийн ундны цэвэр усаар хангах зорилгоор төвийн гүний 2 худагт орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэлтийг гаргаж цэвэршүүлэх төхөөрөмжийг Баялаг говь ХХК гэрээ хийсний дагуу суурилуулан хүлээн авсан.

Ургац хураалтын мэдээгээр төмс 18 тн, хүнсний ногоо 7 тн хураан аваад байна.

**Боловсрол, соёл урлагийн чиглэлээр:** Хичээлийн шинэ жилийн эхэнд хүүхдийн сурч хөгжих тав тухтай таатай орчинг бүрдүүлэхэд 10,000,000 сая төгрөгний тавилга, гал тогооны тоног төхөөрөмжийг Цэцэрлэгт санхүүжүүллээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/155 дугаар захирамжийн хүрээнд сумын ЗДТГ, Соёлын төв хамтран “УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ, УДМЫН САНГАА ХАМГААЛЬЯ” уралдааны удирдамжийг батлуулж 2 сая төгрөгийн шагналын санг сумын Засаг даргын нөөцөөс шийдвэрлээд ажиллаж байна.

2021 оны 9 дүгээр сарын 21-22 -нд БШУЯ, Боловсролын үнэлгээний БҮТ-н хамтарсан “онол-үнэлгээний сорил”-ийг 12 дугаар ангиудад зохион байгуулах ажлын хүрээнд хянагчаар ажиллах багш нарын сургалтыг зохион байгуулсан.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** ЭМЯ-наас 2021 оны 08 сарын 30 ны өдөр Ковид-19 цар тахалын үеийн халдваргүйтэл хамгаалалтын талаар зохион байгуулсан сургалтад ЕБС, Цэцэрлэг, ЭМТ-ийн эмч, арга зүйч нар хамрагдсан.

Эрүүл мэндийн цахим зөвлөмж: 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр Аймгийн нэгдсэн эмнэлэгийн сэтгэл зүйч А.Адъяасүрэн эмч “Ковидын үеийн ажлын байрны сэтгэлзүй”-н цахим зөвлөмжийг өгсөн. Үүнд 54-44 багш, ажилчид хамрагдаж 81,4 %-н ирцтэй хамрагдсан.

КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлын мэдээгээр: гэрийн эмчилгээнд 26, ойрын хавьталд 189 нийт 215 иргэн хяналтад байна.

Сумын Ахмадын хорооны урилгаар Монгол улсын гавьяат эмч Цулбуур эмч 9 хоног ажиллаж 300 гаруй иргэнд оношилгоо хийснээс 165 ахмад оношилгоонд хамрагдлаа.

### **Мөнххаан:**

**Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний чиглэлээр:** Мөнххаан суманд Ковид-19-ын 387 тохиолдол бүртгэгдээд байна. Сумын эмнэлэгт 62 хүн тусгаарлагдан эмчлүүлж байна. /Том хүн 48, хүүхэд 14/ гэрээр 28 хүн

эмчлэгдэж байна. Хүлээгдэж буй пгу шинжилгээ 16 байна. Сумын шуурхай штабын жижүүр хуваарийн дагуу 83177070 утсаар мэдээ мэдээллийг авч ажиллаж байна.

**Төсөв санхүүгийн хүрээнд:** ОНХС-ын хөрөнгө оруулалтаар сумын төвийн 400м хатуу хучилттай замын ажлыг Ханан салхит ХХК хийж гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 70%-тай явж байна.

Шүүхэд сум хөгжүүлэх сангийн 35 зээлдэгчийн 118949952 төгрөгний төлөлтийг хийлгүүлэх талаар материал бүрдүүлж хүргүүлсэн. Үүнээс энэ онд шүүхэд хандаж өргөдөлөгсөн 23 зээлдэгчийн 724674767 төгрөг байна. Иргэний шүүхэд шилжүүлж прокурор оролцох 5 зээл, эвлэрүүлэн зуучлалаар хандсан 10 зээл, шүүхийн тоот гаргуулах 8 зээл байна.

Аймгийн шүүхийн тамгын газар, шүүгчийн бүрэлдхүүн ирж 1 өдөр ажилласан. Төрийн аудитын ажлын хэсэг ирж сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, хадлангийн газар олголтын ажилд явцын аудит хийж зөвлөмж чиглэл өгч ажилласан.

**Нийгмийн хамгааллын чиглэлээр:** 3-р багийн иргэн гэр оронгүй, ах дүү хамаатан садан байхгүй өндөр настан 1 иргэнийг Зөв амьдрах ухаан ТББ-тай утсаар холбогдсоны үндсэн дээр тухайн газарт хүлээлгэн өгч ажилласан.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** **Вакцинжуулалт:** Верроцил 1-р тунд 2693, 2-р тунд 2552, 3-р тунд 148 хүн нийт 5393 хүн хамрагдсан. Файзер 1-р тунд 583 хүн, 2-р тунд 268 хүн 3-р тунд 94 хүн нийт 1248 хүн хамрагдсан. Голомтын ариутгал 476 м/кв батлагдсан тохиолдлын гэр байшинд ариутгал халдваргүйтгэл хийсэн. Нөөц 7-14 хоногийнх байна.

**ЕБС:** 2021 оны 09 сарын 20-ний өдрөөс эхлэн тус сургуулийн 6-11 насны буюу 1-6-р ангийн сурагчдыг томуугийн эсрэг вакцинжуулалтад хамруулж эхлээд байна.

2021 оны 09 сарын 23, 24-ний өдрүүдэд Сүхбаатар аймгийн Боловсрол Соёл Урлагийн газрын мэргэжилтнүүд тус сургуулийн 2-12 дугаар ангийн нийт сурагчдаас түүврийн аргаар “Түвшин тогтоох шалгалт”-ыг авч байна.

2021 оны ЭЕШ-д бэлтгэсэн сурагчид нь улс, аймгийн дунджаас дээгүүр оноотой үнэлэгдсэн багш нарт сургуулийн дотоод журамд заасны дагуу туслах аж ахуйгаас тус бүр 1 хонь олгосон.

Багш ажилчид болон сурагчдыг интернетийн эх үүсвэрээр хангах зорилгоор Мобинет ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан сургуулийн дотоод орчинд утасгүй интернетийн төхөөрөмж байршуулан ашиглаж эхлээд байна.

**Хүүхдийн цэцэрлэг:** Хүүхдийн цэцэрлэг нь 2021-2022 оны хичээлийн жилд нийт 7 бүлэгтэйгээр танхим ба зайн гэсэн хосолсон хэлбэрээр сургалт үйл ажиллагаа зохион явагдаж байна. Үүнээс 4 настай 3 бүлгийн 90 хүүхэд, 5 настай 4 бүлгийн 93 хүүхэднийг 163 хүүхэд СӨБ-ыг эзэмшинэ.

Танхимаар хичээллэж буй 7 бүлэгт 130 хүүхэд хамрагдаж, халдвар хамгааллын дэглэмээ баримтлан сургалтын үйл ажиллагаа танхимаар хэвийн явагдаж байна. 4-5 настай 26 хүүхэд, 3 настай 50 хүүхэд нийт 76 хүүхэд зайнаас хичээллэж байна. Бүлгийн багш нар сургалтын материалыг боловсруулан хүргэж, бүлгийнхээ цахим хаягаар мэдээллээ хүргэж ажиллаж байна.

**Нийгмийн хамгааллын чиглэлээр:** Хөдөлмөрт бэлтгэх залуучуудын “ОРОЛЦОО” төсөлд тус сумаас 4 иргэн бүртгүүлж амжилттай оролцсон. Малжуулах хөтөлбөрийн хүрээнд 3-р багийн малчин Б.Очирпүрэв 5,0 сая төгрөгийн 43 тооны малыг 1-р багийн малчин Аймгийн сайн малчин Б.Баттөмөрийнхөөс хүлээн авсан.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөрийн зах зээлийн эрэл нийлүүлэлтийн судалгаа 2021.09.11-13 хүртэл 3 хоног явагдаж судалгааны 5 төрлөөр 400 гаруй иргэд, ААНэгж, малчдаас судалгаа авсан.

Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төслийн бүртгэлд 18-34 насны 6 иргэн хамрагдах саналаа өгч бүртгүүлсэн байна.

**Мал эмнэлгийн болон ХХАА-н чиглэлээр:** Бруцеллёзын вакцинжуулалтанд 7356 тугал, хурга 66713, ишиг 45461, бүгд 119530 толгой төл мал хамрагдсан ба сумын хэмжээний бүх хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний шинжилгээнд хамруулахаас одоогийн байдлаар 65

бух, 468 хуц, 246 ухна, нийт 779 хээлтүүлэгчээс цус авч ийлдсийг ялган шинжлүүлэхээр аймгийн мал эмнэлгийн лабораторид илгээгээд байна. Үхрийн арьс товруутах өвчин Дорнод болон Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Сүхбаатар сумдад оношлогдсонтой холбогдуулан халдвар бүртгэгдсэн аймаг сумаас малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх сэрэмжлүүлэх зөвлөмжийг малчдад хүргэж ажиллаж байна.

**Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:** Тус сумын 5-р багийн нутаг болох Бүрэнцогт уул уурхайн эвдэрсэн газарт 1гад нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэхээр аймгийн ажлын хэсэг ирж газартай танилцаж “Эм эл Цахиур овоо” ХХК-аар хийлгэсэн.

Нэгдсэн хогийн цэгийн тэлсэн хог хаягдлыг түрэх ажил хийгдэж байна.

Сумын хэмжээнд 7 хадлангийн салаанд гэрээ байгуулан газрыг олгосон.

### **Наран:**

**Ерөнхий боловсрол:** 2021-2022 оны хичээлийн жилийн сургалт хүмүүжлийн ажил 278 сурагч 36 багш ажилтантай явагдаж байна. Үүнээс: Бага боловсролд 181, суурь боловсролд 97 сурагч байна.

**Сургуулийн өмнөх боловсрол:** Цар тахалтай холбогдуулан 4,5 настай 77 хүүхдийн эцэг эхтэй холбогдон тэдний санал хүсэлтийн дагуу 62 хүүхдийг бүртгэж, 13 хүүхдийг хувилбарт сургалтанд хамруулан жишиг даалгавар боловсруулж, СӨБ-ыг үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

3 настай Дунд бүлгийн 21 хүүхдүүд нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зайнаас суралцаж байна.

Цэцэрлэгийн гадна 2ш, дотор 6ш камерыг болон дэлгэц хураах төхөөрөмж зэрэг 2.980.000 төгрөгний үнэ бүхий камержуулалтыг бүрэн шинэчилсэн.

**Байгаль орчны чиглэлээр:** Дарьганга сумын нутагт хадлангийн салаа гарахтай холбогдуулан хадлан авах талбайг Дарьганга сумын засаг даргатай хамт очиж хэмжиж хадлангийн салаанд хүлээлгэн өглөө. Мөн Баяндулаан уул орчмын нутагт хадлангийн 3 салаанд 2000 га талбайг хэмжиж, гэрээ байгуулан ажиллаж байна.

Монгол тарваганы тархац байршил, тоо толгойг гаргах зорилгоор сумын 1-р багийн нутаг болох Хайрханы ширээ, 2-р багийн нутаг болох Баяндулаан уул орчмын нутагт тарваганы мониторинг судалгааг хийж өглөө оройн гарааг харсан. Нийт 15 дош байсан бөгөөд ойролцоогоор 8 тарч, 5 бурхи, 10 гаруй мөндөл байсан.

Аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвөөс бэлчээр талхлалтын явуулын судалгаа хийж гүйцэтгэсний зэрэгцээ 1, 2-р багийн нутагт 13 цэгт бэлчээрийн фото мониторингийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** Малын үүлдэр угсааг сайжруулах, сүрэг сэлбэх зорилгоор Эрдэнэцагааны үзэмчин үүлдэрийн 20 ш хурган хуцыг авчирч ирэх жилд үржилд ашиглахаар бойжуулж байна.

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:** Залуучуудын хөдөлмөрт бэлтгэх оролцоо төслийн сургалтад 5 залууг хамруулж 2 иргэнийг суманд ЭМТ, Соёлын төвд 3 залууг аймгийн төвд дадлага хийлгэхээр болоод байна.

“Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны баг ирж суманд 2 өдөр ажилласан малчин өрх-60, төсөвт байгууллага-5, ажилгүй иргэн -70, ажил хөдөлмөр эрхэлж байгаа 18-35 насны -60, хувиараа хөдөлмөр эрхлэгч-30, ААНБ-9 иргэнээс судалгааг авсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, цар тахлын үед аж ахуй нэгжийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр зарлагдсантай холбогдуулж 3 иргэнд мэдээлэл өгөн 3 төслийг хүлээн авч ХХҮГ-т хүргүүлээд байна.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:** Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж асаргаа сунгуулах 2 иргэний, ахмадын баяраар хүндэтгэл үзүүлэх байгууллагын харьяалалгүй ахмадын асуудлыг хэлэлцсэн.

Зорилтот бүлгийн 5 өрхөд ямаа төслийн ямаа олгож ахуй амьдралыг нь дэмжин ажиллаж байна.

### **Сүхбаатар:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** 2021 оны 9 сарын 8-15 ны өдрүүдэд Багийн Засаг дарга, болон Багийн Иргэдийн Нийтийн хурлын даргыг сонгох сонгууль зохион байгуулагдаж, томилогдох багийн Засаг дарга нарын материалыг хянуулахаар Авилгатай тэмцэх газарт хүргүүлээд байна.

2017 оноос ЗДТГ-аас санаачлан хэрэгжүүлж байгаа малжуулах хөтөлбөрийн эргэлтийн санг 20 өрхөөс цуглаан 100 хургийг малчинд хүлээлгэн өглөө.

**Соёл урлаг, Боловсролын чиглэлээр:** Соёл урлагийн ажилтны баярт зориулан Сүхбаатар сумын соёлын төвийн хамт олноос баярын цахим мэндчилгээ бэлтгэн хүргэсэн. Цахимаар 1200 хүнд хүрсэн.

"Соёл урлагийн ажилтны баяр"-ыг угтан сумынхаа түүх соёлыг судлан дэлгэрүүлж, урлагийн бүтээл туурвилыг нь мөнхлөн түгээх, нутгийн тухай дуу хуурыг олон нийтэд сурталчилан таниулах зорилготой "НУТГИЙН ДУУГ ХЭН САЙН ДУУЛАХ ВЭ" цахим уралдааныг зохион байгуулсан.

Сүхбаатар сумын соёлын төв "Лед дэлгэц" нийлүүлэх тендер шалгаруулалтанд Улаанбаатар хотын "Электронтехник" ХХК шалгарч, 2021 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр 47,925,500 төгрөгний үнэ бүхий лед дэлгэцээ хүлээн авсан.

2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 12 үйл ажиллагаа зохион байгуулж, цахимаар 6037 хүнд хүрч ажилласан.

2021-2022 оны хичээлийн шинэ жилийн нээлттийн үйл ажиллагааг цахимаар цэцэрлэгийн хаягаар дамжуулан хүргэсэн.

Аймгийн мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт шалгалтын ажлын хэсэгирж цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж БШУ-ын сайд ЭМ-сайдын хамтарсан А/292 А/525 тушаалын хэрэгжилтийн явцтай танилцаж ажилласан ба уг шалгалтаар бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Сүхбаатар сумын хэмжээнд 2-11 настай хүүхдийн томуугийн урьдчилан сэргийлэх вакциныг 41% тай 2-5 настай хүүхдийг хамруулсан.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Эрүүл Мэнд боловсрол сангийн санхүүжилтээр 126689000 төгрөгөөр Эрүүл мэндийн төвийн байрыг засварласан.

Ариутгалын багц-150 өрхөд 11936 төгрөгийн багц хүргэсэн. Эмийн багц том хүнд-200 хүүхдэд-70 хүний багцыг бэлдэж хүргэж эхэлсэн.

### **Түвшинширээ:**

09 дүгээр сарын 27-ны өдөр сумын Засаг даргын "Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай" А/87 тоот захирамж гарч сумын нутаг дэвсгэрт хэсэгчилсэн хорио цээрийн дэглэмийг 10 дугаар сарын 04-ний өдрийн 18.00 цаг хүртэл тогтоолоо. Хэсэгчилсэн хорио цээрийн дэглэмийн хугацаанд "Нэг өрх, нэг шинжилгээ" арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна.

2021 оны 09 дугаар сарын байдлаар сумын нийт хүн ам 3429, сумын нийт өрх 977, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн хүүхэд 9 дүгээр сарын байдлаар 50, нас барсан 12 хүн бүртгэгдсэн байна.

**Хөрөнгө оруулалтын чиглэлээр:** Сумын төвийн хогийн цэгийг цэгцлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нээж, хянан үзээд "Элимент медикал" ХХК-г шалгаруулан гэрээ байгуулах эрх олгоод байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажил 100% хийгдэж, ажлын комисс хүлээн аваад байна. Сумын төвийн камержуулалтын ажил 80%-тай явагдаж байна.

Улсад төвлөрүүлэх төвлөрсөн төсвийн орлогод 4200,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4595.4 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 109.0 хувиар буюу 395.4 мянган төгрөгөөр, аймаг төвлөрүүлэх татварын орлогод 81879.2 мянган төгрөг төвлөрүүлэхээс 102566.6 мянган

төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 125.3 хувиар буюу 20687.4 мянган төгрөгөөр, сум орон нутгийн татварын орлогод 24656.3 мянган төгрөг төвлөрүүлэхээс 81248.2 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 329.5 хувиар буюу 56591.9 мянган төгрөгөөр, нийт татварын орлогод 110735.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 188410.2 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 170.1 хувиар буюу 77674.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан.

Тус сумын Өлзийт 2-р багийн нутагт нутагладаг өөр аймаг сумын 7 өрхөөс бэлчээрийн төлбөрийг хурааж Засаг даргын тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулав.

Үнэгт 3-р багийн нутаг Талын толгой, Хаяа гэх нутагт нутаглаж буй Дундговь аймгийн харъяат 2 малчин өрхөд бэлчээр газар нутгийг чөлөөлөх талаар мэдэгдэл хүргэсэн.

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бэлчээрийн зориулалтын гүн өрмийн худаг гаргаж "Golden hill" ХХК –ны үйл ажиллагаатай танилцаж хяналт тавьж ажилласан.

Өгөөмөр багийн малчдын мэдээллийн дагуу шонхор шувуу зөвшөөрөлгүй барьж байсан гадаадын иргэдийн үйлдлийг таслан зогсоож, Арабын Катар улсын иргэн Мохаммедтэй 40 тагтаа, 80 ногтруу барих гэрээ байгуулж тагтааг 5000 төгрөг, ногтрууг 8000 төгрөгөөр тооцож нийт 840000 төгрөгийг төрийн сангийн дансанд байршуулсан.

Охин төл малд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийгдэж байна. Вакцинжуулалтын явц 85%-тай байна. Нийт 1897 хээлтүүлэгч малаас бруцеллозийн шинжилгээнд цусны дээж авсан байна.

Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил сумын Засаг даргын захирамжийн дагуу хийгдэж байна. Мал угаалгын ажилд 4 ажлын хэсэг гарч 8 угаалгын ваннд ванндаж угааж байна. Одоогийн байдлаар 50 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.

**Хөдөө аж ахуй, байгаль орчин:** Сумын хүнсний дэлгүүрүүдэд мэргэжлийн хяналтын газраас ирсэн шалгалтын хүснэгтийн дагуу шалгалт хийж заавар зөвлөгөөг өгч 9 дэлгүүр , 2 хоолны газарт шалгалт хийж, илэрч гарсан зөрчлүүдийг арилгах арга хэмжээг авч ажиллахыг хариуцсан аж ахуй нэгж иргэнд даалгаад байна.

Монгол улсын ШУА, Боловсрол суваг телевиз хамтран тус сумын танилцуулга сум орон нутгийн түүх дурсгал уул усны талаар мэдээлэл бэлтгэн зураг авалт хийж орон нутгийн иргэдээс мэдээлэл, ярилцлага цуглуулж бэлтгэх ажилд 2 өдрийн туршид 200 км зам туулан ажилласан.

ШУА-н археологийн судалгааны ажилчдын дунд үүссэн маргааныг зохицуулж "ЭБНЭ" ХХК-ний үйл ажиллагаатай танилцаж, гэрээ хэлэлцээр байгуулах талаар ярилцаж тохиролцсон.

Тус сумын Өлзийт багийн нутаг Оорцогийн ууланд археологийн судалгааны судалгааны үйл ажиллагаа явуулж буй Монгол улсын Чингис хааны музейн үзмэр, ШУА-н үйл ажиллагаатай танилцаж судалгааны ажлын үр дүн, явцын байдалтай газар нь танилцаж холбогдох мэдээ мэдээлэл ойлголт авч нутгийн малчид ард иргэд танилцуулан ажиллаж байна.

Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил сумын Засаг даргын захирамжийн дагуу хийгдэж байна. Мал угаалгын ажилд 4 ажлын хэсэг гарч 8 угаалгын ваннд ванндаж угааж байна. Одоогийн байдлаар 40 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шүлхийн вакцин 100% хийгдэж дуусаад байна.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадаа талбайг ариутгаад байна.

**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж:** Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч бүртгэгдэж, ажлын байранд 2 иргэний мэдээллийг зуучилсан.

"Хөдөлмөрийн зах зээлийн дэх эрэлт нийлүүлэлт" судалгаа явагдахтай холбогдуулан багийн Засаг дарга нартай хамтран малчин өрх-141, 18-34 насны ажил хөдөлмөр эрхэлж буй залуучууд-61, ААНэгжүүд-11, Хувиараа хөдөлмөр эрхлэгч-22, ажилгүй иргэн-41 нарын судалгааг гарган өгсөн. Мөн залуучуудыг орон нутагт хөдөлмөрт бэлтгэх төслийн сургалтад хамрагдах 5 иргэдэд гэрээг бэлтгэн өгч хамруулсан.

Нийгмийн халамжийн хугацаагүй тэтгэвэр авч буй 15 иргэний судалгааг гаргалаа. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 22 өрхийн 99 иргэн хамрагдаж байна.

**Боловсролын чиглэлээр:** Боловсролын 100 жилийн ойтой холбоотойгоор сургуульд ажиллаж байсан ахмад захирал, хичээлийн эрхлэгч, багш нарын нэрсийг гаргаж, үр хүүхдүүдэд нь хандаж ЦАХИМ орчинд тэднийг алдаршуулах БИДНИЙ БАХАРХАЛ цувралыг бэлтгэж эхлээд байна.

Түвшинширээ сумын нутаг дэвсгэрт буй чулуун соёлын дурсгал, хадны бичиг, булшнууд зэрэг “ БИДНИЙ БАХАРХАЛ”-т түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үнэ цэнэ дахин давтагдахгүй байдал түүний ач холбогдлыг сурталчлах арга хэмжээг авч ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар бага ангид танхимаар 154 хүүхэд цахимаар 226 хүүхэд хичээллэж байна.

**Хүүхдийн цэцэрлэг:** Цэцэрлэгийн барилгын 1 давхарын 2 ангийн шал, коридорын шал доош цөмөрч хүүхэд хүлээн авах боломжгүй болж холбогдох газруудад хүсэлт тавьж 7 сараас эхлэн барилгын компани засварын ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ хугацаанд борооны улмаас дахин асуудал үүссэнийг сумын онцгой комисстой хамтран дээд газруудад хүсэлт тавьсны үр дүнд Барилга хөгжлийн төв, аймгийн ГХБХБГазраас хамтарсан шалгалт ирж зохих үүрэг чиглэлийг өгсөнөөр 9 сарын 1-нд дээд давхартаа 5 настай 4 бүлэг, 9 сарын 13-нд засвар дуусч доод давхарт 2 бүлэг хүлээн авч үйл ажиллагаа жигдэрлээ.

Орон нутгийн хөгжүүлэх сангийн хөрөнгөөр гадна 2ш дотор 10ш камер суурьлуулж өөрийн хуучин камертайгаа нийт гадна 2ш, дотор 24ш камертай боллоо.

**Соёл:** Монголд соёл урлагийн байгууллага үүсэн байгуулагдсны 100 жилийн ой, Соёлын ажилтны 28 дахь удаагийн баярын өдрийг тохиолдуулан баярын мэндчилгээ, live тоглолтыг зохион байгууллаа.

Угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтыг байгууллагын 9 албан хаагчдад зохион байгуулаад байна. Соёлын төвөөс “Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалъя” уралдааныг зохион байгуулж, удирамжийг иргэд, албан байгууллагуудад хүргээд байна.

**Эрүүл мэнд:** Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторын нийт үзлэг 277, алсын дуудлага 11, гэрийн дуудлага 15, хэвтэн эмчлүүлэгч 7, хэвтэн эмчлүүлэгч Ковид /Халдвартай бүс/ - хэвтэн эмчлүүлж байгаа 28. Нас баралт 0.

Энэ сард сард сард нийт 638 хүнээс шинжилгээ, коронавирусын гоц халдвар 225 ширхэг бүртгэгдээд байна. Улаан бүсэд 2 баг 10 хоногоор ээлжлэн ажиллаж байна. ЭМТ-ийн нийт 21 ажилтнаас 14 ажилтан ковидын халдвар авсан байна.

#### **Түмэнцогт:**

**Хууль эрх зүйн чиглэлээр:** Ковид-19 цар цахалтай холбоотой Улсын Онцгой комиссын албан даалгавар, ЗГ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч цахимаар 56 төрлийн мэдээллийг сумын 3 группээр дамжуулан иргэдэд хүргэсэн.

Шинэчлэгдэн найруулагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд цахимаар 3 төрлийн мэдээлэл 20 гаруй удаагийн давтамжтай хүргэсэн.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөл байгуулж худалдаа үйлчилгээ эрхэлдэг ААНэгжүүдэд хяналт тавьж, заавар зөвлөмж, сургалт зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:** Ажил хайгч 7 иргэдийн мэдээллийг “LIMS” праграммд шинэчилж бүртгэсэн.

Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан 6 иргэний тодорхойлолтыг гаргаж Нийгмийн даатгалын байцаагчид хүргүүлсэн.

Зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн багийн ажлын хэсэг 2021.09.08-09.10-ны өдөр хүртэл 3 өдөр ажиллаж сумын 60 малчин, ажил хөдөлмөр эрхэлж буй 23 залуучууд, 78

ажилгүй иргэд, аж ахуйн нэгж байгууллага болон төрийн бүх байгууллагаас, хувиараа хөдөлмөр эрхлэгч 15 иргэнээс маягтын дагуу судалгааг авч ажилласан.

Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах төслийг нөөц бааз суурь дээрээ тулгуурлан сумын Засаг дарга 600000 төгрөгний үнэ бүхий 10 шуудай 400 кг төмсийг зорилтот бүлгийн 10 иргэнд хувааирлан өгч тариулж “Ахмад мэргэжилтэнээр зөвлөн туслах үйлчилгээ” үзүүлж 0,5 га талбайд тариалсан. Ургац хураалтын ажлыг 2021.09.18-19 өдрүүдэд зохион байгуулж ажилласан.

Зорилтот өрх тус бүр 40кг төмс тариалсанаас 2 өрх 168кг төмс, 3 өрх 264 кг төмс, 1 өрх 375 кг төмс, 2 өрх 105кг төмс, 2 өрх 195 кг төмс нийт 2тн214кг төмс хураан авч өрхийн хүнсний хэрэгцээг хангахаас гадна борлуулалт хийн өрхийн орлогыг нэмэгдүүлсэн.

Залуучуудад эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгож, ажилтай, орлоготой болгох зорилготой “ОРОЛЦОО” төсөлд 18-34 насны, сүүлийн 3 сар ажил, хөдөлмөр эрхлээгүй, их дээд сургууль болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцдаггүй ажилтай, орлоготой болж ирээдүйгээ өөрчлөх хүсэлтэй 8 залуучуудыг бүртгэж 6 залуу Улаанбаатар хотын 14 хоног вакумжуулсан сургалтад амжилттай хамрагдсан. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 1 иргэн худалдааны зөвлөхөөр, Сүхбаатар аймаг 1 иргэн гоо сайхны чиглэлээр дадлагад гараад байна. Орон нутгийн Уул уурхайн салбарт 3 иргэн тогоочоор 1 иргэн жолоочоор дадлагат гарах төлөвлөгөөтэй бүртгүүлээд байна.

Санхүүгийн дэмжлэг болох Итгэлийн зээлд хамрагдсан иргэн төлөвлөгөөний дагуу эргэн төлөлтийг хийсэн.

“Түмэнцогт суманд үйлдвэрлэв” борлуулалтын цэгт 13 иргэний бараа бүтээгдэхүүнийг борлуулж нийт 832.000 төгрөгний борлуулт хийж тус цэгийн цахим хуудсанд мэдээ, мэдээлэл оруулж иргэдэд бараа бүтээгдэхүүнийг сурталчилж ажиллаж байна.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:** 2021.09.06-ны өдөр галын аюулын улмаас орон гэргүй болсон 13 өрхийн материалыг бүрдүүлж амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэхэд бэлэн болгож ажилласан. Аймгийн онцгой байдлын газрын галын дүгнэлт гараагүй байгаа тул тухайн материалыг хурлаар хэлэлцээгүй хүлээгдэж байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 40 өрхийн 9 сарын олголтын жагсаалтыг маягтын хамт хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж байгаа хүнсний дэлгүүрт хэвлэн өгч олголтын ажлыг чирэгдэлгүй зохион байгуулж байна.

### **Халзан:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** Гамшгаас хамгаалах зардлыг ИТХ аас 10 сая төгрөгөөр тодотгол хийж 20 ширхэг эвхдэг ор авч ажиллав.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг нийт төрийн албан байгууллагуудаас авч нэгтгэн хүргүүлэн ажиллав. Мөн сул орон тооны зарыг аймгийн ТЗУХ-т хүргүүлээ

**Төсөв, санхүү:** Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс энэ сард 944,0 мянган төгрөг дансанд төвлөрч, дансны үлдэгдэл 121043,1 мянган төгрөг байна.

ОНХС-ийн дансны үлдэгдэл 32021,0 мянган төгрөг байна. Энэ сард Гамшгаас хамгаалах зардалд 10000,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, зарцуулалт 5168,5 мянган төгрөг гарч, дансны үлдэгдэл 4831,5 мянган төгрөг байна.

**Соёлын чиглэлээр:** Халзан сум соёлын төвийн үйл ажиллагаа нь цар тахалтай холбоотойгоор олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байна. Корона вирусын тархац эрчимтэй нэмэгдэж эрүүл мэндийн төв ачаалалаа дийлэхгүй болж Соёлын төвийг тусгаарлан ажиглах эмчлэх байр болгон ажиллаж байна.

Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан Дарьганга марзай уралдаанд соёлын төвийн ажилтан Б.Батбаатар 2 хүүхэд бэлтгэн оролцуулан идэвхи санаачлагатай ажиллаж гутгаар, тусгай байранд тус тус шалгарсан.



**Эрүүл мэндийн чиглэлээр:** 9 дүгээр нийт сард батлагдсан тохиолдол болох 78 иргэнийг эмнэлэгт эмчилж ажиллаж байна. Улаан бүсэд 1 их эмч, 1 сувилагч, 1 үйлчлэгч 14 хоноод 2 дахь ээлжийн 1 бага эмч, 2 үйлчлэгч 2 сувилагч ажиллаж байна. Тандалтын 2 баг ажиллаж, батлагдсан иргэдийн ар гэрийн ойрын хавьтал тогтоох, ариутгал халдваргүйтгэл хийх ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Нийт 240 иргэнээс түргэвчилсэн шинжилгээ авч ажилласан. Одоогийн байдлаар сумын эмнэлэгт 46 хүн хэвтэн эмчүүлж байгаагаас 1 хүний биеийн байдал хүндэвтэр, 1 хүн сэжиглэн эмчлэгдэж, 45 хүн хөнгөн байна. Үүнээс 9 хүүхэд байна, жирэмсэн байхгүй.

9 дүгээр сарын 24 ны байдлаар 2 -12 насны 190 хүүхэд томуугийн вакцинд хамрагдаад байна.

**Жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн чиглэлээр:** 2021 оны 09-р сарын 22-ны байдлаар нийт 9 зээлдэгч байгаагаас 2021 оны 09 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 3 хүнээс 944.000 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна. Нийт зээлдүүлэгч нартай утсаар болон биеэр очиж уулзан хугацаандаа зээлээ эргэн төлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Сум хөгжүүлэх сангийн зээлдэгч Ц.Идэрбатыг дэмжих зорилгоор Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-н захирал нартай уулзаж сүү сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хийж ажилласан.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** “Тэргүүн сүрэг” ХХК-тай 1212500 төгрөгний бод богийн ээмэгний гэрээ байгуулан, захиалгын дагуу ээмгээ хүлээн авч, үржлийн малын ангилалт, баталгаажуулалт, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах сумын засаг даргын захирамжаар ажлын хэсгийг томилон ээмэгжүүлэлтийн ажил эхлэлээ.

2021-2022 оны Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах аймгийн засаг даргын 07 албан даалгаварын дагуу сумын засаг даргын албан даалгавар гарган төлөвлөгөө гарган ажиллаж байна.

**Мал эмнэлэгийн чиглэлээр:** Шүлхийн вакцины нэгтгэлийг мал эмнэлгийн нэгтсэн системд оруулж мал эмнэлгийн газартай тулгалт хийж дууссан. Орон нутгийн захиалгат Дуут, боом, дхх, лестериоз, сахуу, цусан халдвартын вакцин хийгдэж дуусаад нэгтгэх шатандаа явж байна. Мал эмнэлгийн ерөнхий газраас зохион байгуулсан зайны сургалтад тасгийн байцаагч нар хамрагдсан.

Хээлтүүлэгч малын шинжилгээний ажил эхлээд 20 хувьтай явагдаж байна, нийт 4 мал эмнэлгийн 5 малын эмч ажиллаж байна.

**Байгаль орчны чиглэлээр:** Ой хээрийн түймэрийн эрсдэлийн үнэлгээг гаргаж аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэн ажиллав.

Шонхор шувуу барих отгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ойр орчмын хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг нийт 3 удаа зохион байгуулж ажиллалаа.

#### **Уулбаян:**

Сумын Засаг даргын 2021 оны 9 сарын 20-ны өдрийн А/132 дугаар захирамжаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 09 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл сумын нутаг дэвсгэрт хэсэгчилсэн хорио цээрийн дэглэм тогтоосон.

9 дүгээр сарын байдлаар шинээр төрсөн -5, үүнээс эрэгтэй – 2, эмэгтэй-3, үрчилсний бүртгэл-1, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 1 тус тус бүртгэгдсэн байна.

9 дүгээр сарын байдлаар Хулгайлах гэмт хэрэг-2, Залилах гэмт хэрэг-1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих-4, танхайрах-1 тус тус зөрчил гарсан байна.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Чийрэгжүүлэлтийн танхим байгуулах тендерийг зарлаж 35,0 сая төгрөгөөр Санаа мед трейд ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгоод гэрээг байгуулсан.

Сургуулийн дотуур байр шинээр ашиглалтанд орж цэвэр усныг 10,0 сая төгрөгөөр хийх гэрээ байгуулан ажиллаж байна.

**Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр:** 2021.09.22-ны байдлаар 2011-2020 оны хооронд зээл авсан 30 зээлдэгчийн 252,800,000 төгрөгийн зээл олгосон байна. Бодогдсон хүү нь 13,627,342 төгрөг. Үүнээс, зээлийн хүү, алданги ороод 115,442,314 төгрөг эргэн төлөгдсөн. Нийт үлдэгдэл 146.625.028 төгрөг байна.

Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 73,4 % байна. 8 сарын 30 байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 609677 төгрөг сум хөгжүүлэх санд орж ирсэн байна.

**Газар зохион байгуулалтын чиглэлээр:** Иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоосон Засгийн газрын 2021 оны 262 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 15-ныг хүртэл хугацаанд иргэдийн газар өмчлөх өргөдлийг хүлээн авсан. Мөн Засаг даргын захирамж гарган Засаг даргын орлогчоор ахлуулсан 4 гишүүнтэй ажлын хэсэг байгуулан нийт 28 өргөдөл ирүүлснээс 22 өргөдлийг шийдвэрлэсэн.

**Ногоон байгууламжийн чилэлээр:** Сумын жишиг хорооллын ногоон байгууламжийн хашааны эвдрэл гэмтлийг засах, засвар үйлчилгээний ажлыг хийж дууслаа. Хашааг өндөрлөх ажилд зорилтот бүлгийн иргэдээс сонгон авч ажилуулсан. Мөн сумын төвийн Баясгалант талбайн ногоон байгууламжийн хашаа засварлах, будах, сэргээх ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** Үржлийн малыг ангилан ялгах бүртгэлжүүлэн цөм сүрэг бүрдүүлэх ажлын хүрээнд аймагтаа анхдагч сум болж ХААГ-н мэргэжилтэнүүдтэй хамтран Дэлгэр багийн Базарханд малчны үхэр-8 толгой, хонь-75 толгой, ямаа-48 толгой малд ангилан ялгалт, ээмэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж сумынхаа мэргэжилтэнүүд болон багийн засаг дарга нарт практик сургалт зохион байгуулав.

2021 оны 9 сарын 7-ны өдрөөс эхлэн хүнс худалдаа, хоол үйлдвэр үйлчилгээ эрхэлдэг 10 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 7 хоногийн Мягмар, Пүрэв гарагт тогтмол хяналт шалгалт хийж, мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн, хавсралт хүснэгтийн дагуу зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг сумын хэмжээний охин төлд хийж дууссан. Аймгийн мал эмнэлгийн газарт мэдээг урьдчилсан байдлаар өгөөд байна.

2021 оны шимэгтчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтын арга хэмжээ хийгдэж байна.

### **Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:**

**Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:** Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д ажил хайгчаар бүртгэсэн 10 иргэнийг сэргээсэн. Шинэ ажлын байранд 5 иргэн, зуучлагдсан 15 иргэнийг шинээр бүртгэсэн. Аймгийн хэмжээнд анх удаа зохион байгуулж байгаа Хөдөлмөр эрхлэлтийн зургаан том судалгааг цаг хугацаанд хийж явуулсаан.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:** 2021 оны 09 сард Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд жирэмсэн эхийн тэтгэмжинд 4 иргэн, цалинтай эхийн тэтгэмжинд 2 иргэнийг бүртгэсэн.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 391382.5 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ. Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -331034.5 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 48010.8 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 12355.0 мян төг орлоо.

СДДаатгалд 168 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 48010.8 мян төгрөгийн шимтгэл, Эрүүл мэндийн даатгалд 170 даатгуулагчийг даатгаж 12355.0 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-38, тэтгэвэр авах зөвшөөрөл-5, Банк солих-5, тэтгэмж-43, ажилгүйдлын тэтгэмж-11 малчнаар ажилласан жил тогтоолгох-10 нийт 112 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж, 806 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

**Эрүүл мэндийн төв:**

Үзлэгийн мэдээ 2021 оны 9 дүгээр сарын 24 ны байдлаар

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1458
2	Амбулаторийн үзлэг	1129
3	Идэвхтэй хяналт	59
4	Гэрийн эргэлт	96
5	Гэрийн дудлага	209
6	Алсын дуудлага	119
7	Артерийн даралт	560
8	Чихрийн шижин	692
9	Хөхний үзлэг	377
10	Эсийн шинжилгээ	58
11	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	232
12	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	1, 2-р тун 3243, Пейзер вакцины 1,2-р тунд 12-17 нас, жирэмсэн, архаг хуучтай-294, 3-р тунд 254, 2-11 насны томуугийн эсрэг вакцинд 250 иргэн хамрагдаад байна.
13	Түргэвчилсэн тест	1065
14	ПГУ шинжилгээ	327
15	Гэрийн тусгаарлалтад байгаа /ойрын хавьтал/	25
16	Гэрийн эмчилгээнд байгаа	16

**Ерөнхий боловсролын сургууль :** Тус сургуульд 2021-2022 оны хичээлийн жилд нийт 449 суралцагч суралцаж байна.

Шинэ хичээлийн жилийн босгон дээр ахмад багш БТА Т.Дамдинсүрэн сургуулийнхаа гадна хаягийг /монгол бичиг, крилл, англи хэлээр бичүүлж/ шинэчилж сэтгэлийн бэлэг барьлаа.

Багш Б.Оюунжаргал Сүхбаатар аймгийн “Шилдэг багш”-аар шалгарч 3 сая төгрөгөөр шагнуулав.

Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан 75 хүүхдийн ортой дотуур байр шинээр ашиглалтад орж БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 25 сая төгрөгийн гал тогооны иж бүрэн төхөөрөмж, ширээ сандал, хувцасны шүүгээ нийлүүлэгдлээ. Дотуур байранд 50 хүүхэд тус байранд амьдарч байна.

Шинээр ашиглалтад орсон дотуур байранд хүүхэд амьдрах таатай орчин бүрдүүлэхэд эцэг эхийн зүгээс анхаарч одоогийн байдлаар 420,000 төгрөг, 1 бяруу, 2 хонь хандивласан байна.

Сурагчийн оролцооны байгууллагын сурагчид УИХ-ын гишүүн Ж.Батсуурьт санал тавьснаар нэг ангийн ширээ, сандал /18 ширээ, 36 сандал/ нийлүүлэгдлээ.

**Хүүхдийн цэцэрлэг:** 9-р сарын 1-с цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн ажиллаж эхэлсэн ба 4-5 настай нийт 96 хүүхэд танхимын сургалтад хамрагдаж байна.

Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран “Томуугын эсрэг вакцин”-д нийт 68 хүүхдийг хамрууллаа.

**Эрдэнэцагаан:**

**Хууль эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:** 5 багийн Багийн Засаг дарга нарыг сонгох хурлыг 2021 оны 09 дүгээр сарын 08-наас 09 дүгээр сарын 16-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгууллаа.

Өвөлжилтийн бэлтгэл хангах Аймгийн Засаг даргын албан даалгаврыг бүх төсөвт байгууллага ААН, ОНӨҮГазар, зэрэгт хүргэж хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна.

Хилийн бичигт боомтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ажлын хэсэг ажиллаж “Уул уурхайн компаниудтай” хариуцлагын гэрээ байгуулсан ба Петро-Дачин Тамсаг”

компанид бичигт боомтод “PCR”-ийн шинжилгээний тоног төхөөрөмж суурилуулах хүсэлтийг хүргүүлээд байна.

Нийтийн эзэмшлийн талбайд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийж улирал бүр иргэдэд цахим мэдээлэл хүргэж байх комиссыг А/67 тоот захирамжаар баталгаажуулж үүргэжүүлээ.

Ковид-19 халдварт өвчнөөр өвдөж батлагдан гэрийн эмчилгээнд орсон иргэдэд СЗД-ын нөөц сангаас 19.6 сая төгрөг зарцуулан 280 ш багц бэлтгэн иргэдэд өгч сэтгэл санааны дэмжлэг үзүүлээ.

Сумын ЭМТ-д хүчилтөрөгчийн аппарат 3 ширхэгийг төрөл бүрийн эх үүсвэрээс санхүүжүүлэн авч өгсөн.

**ERP системийн ашиглалт:** Сумын засаг даргын 2021 оны 09-р сарын 03-ны өдрийн 1/173 тоот албан даалгавар өгч ERP систем хариуцдаг төсөвт байгууллагын албан хаагчдад танхимаар сургалт зохион байгуулж тус пограммыг ашигладаг талаар мэдээлэл хийсэн. Сумын хэмжээнд төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд төсөвт байгууллагуудыг нэвтрүүлэх явц 36,8% гүйцэтгэлтэй явж байна.

**Сум хөгжүүлэх сангийн хүрээнд:** Сум хөгжүүлэх санд дотоод аудит хийж 2019- 2020 онд олгогдсон 12 зээлдэгчдэд алданги бодогдож, зээлээ төлөөгүй хугацаа хэтэрсэн 4 иргэний материалыг бүрдүүлж иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн.

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт шалгалтын ажлын хэсэгтэй хамтран төсөвт байгууллагууд, 7 ААН-д төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулж эрсдлийг үнэлж бага эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарлаа.

**Сургууль:** Сургуулийн багш ажилчидаас 3 дахь тун вакцинд 63 албан хаагч хамрагдаж 66.3%-тай байна.

Хичээл эхэллээ аяны хүрээнд School police эцэг эхийн эргүүл хуваарийн дагуу сурагчдын хичээлд ирэхэ болон тарах үед машин техникийн хөдөлгөөнийг зохицуулж сурагчдыг эцэг эхчүүдэд гараас гарт нь хүлээлгэн өгөхөд дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

Эх хэлний өдрийг тохиолдуулан үндэсний бичиг үсгээ сурталчлах, түүгээрээ бахархах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын дунд “Үндэсний бичгийн хичээнгүй бичгийн тигээр бичих” уралдаанд манай сургуулийн 40 сурагч бүтээлээ Сүхбаатар аймаг Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг цахим хуудсанд байршуулан олон нийтэд сурталчилан таниулж байна.

**Хүүхдийн 1,2-р цэцэрлэг:** 2021-2022 оны хичээлийн шинэ жилийг эхлүүлэн 4-5 настай 230 хүүхэд танхимаар болон номын багцад хамрагдаж байна.

2-р цэцэрлэг БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн 2 бүлгийн зөөлөн эдлэлийг бүрэн шинэчилсэн, 1 бүлэгт хүүхдийн энгийн хөгжмийн зэмсэгтэй болгож, хоол үйлдвэрлэх байрны тоног төхөөрөмжийг бүрэн шинэжилсэн.

**ЭМТ:** 9-р сард нийт 634 хүнээс шинжилгээ авсан. Үүнээс PCR -61 хүнээс, түргэвчилсэн оношлуураар 573 хүнээс тус тус авсан. PCR шинжилгээний сорьцыг тээвэрлэн 61 удаа АНЭ-т хүргэсэн. Хөхний үзлэгт хамрагдвал зохих 1249 эмэгтэйгээс 720 эмэгтэйг хамруулж 57,6%, Эсийн шинжилгээнд хамрагдах 451 эмэгтэйгээс 200 эмэгтэйг хамруулж 44%-тай байна.

Халдварт өвчнөөс сэргийлэх вакцинд 9 сард нийт 299 хүнийг хамруулсан. Үүнээс: Ковид 19 халдварын эсрэг Вероцилл-86 хүнд, Пфайзер -372 хүнд хийж Товлолын вакцинд 50, Томуу томуу төст-150 хүүхдийг тус тус хамруулсан.

**Нийгмийн даатгал:** Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 5 иргэнийг хамруулж гэрээ байгуулан ажиллаа. Шинээр 10 иргэнд тэтгэвэр тогтоож дээд газарт материалыг нь хүргүүлээ.

**Соёл:** Соёлын ажилчдын баярыг тохиолдуулан “Соёлын ажилчид бидний төсөөллөөр” гар зургийн уралдааныг цахимаар, СББӨ тээгч-Бүтээлч бүсгүйчүүд буланг ажиллуулж бүтээлч бүсгүйчүүдийг цувралаар танилцуулан ажиллаж байна.

“Өвлөгдсөн монгол” кино зураг авалтанд СББӨ тээгч ардын авьяастануудтай, Хутагтын музей, өнө өглөгт хийдээр оруулан тус багийнхантай хамтарч ажилласан.

Иргэн Д.Амарбаясгалангийн олсон олдворыг бүртгэн баримтжууллаа.Номын сангаар 19 хүн үйлчлүүлж, гэрээр 14 ширхэг ном олгон ажиллалаа.

**Малын эрүүл мэндийн хүрээнд:** Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт нь нийт 433684 мал хамрагдсан, мал угаалганд 85280 хамрагдаад байна. Дархлаажуулалтанд нийт 88250 мал хамрагдахаар төлөвлөж , вакцинжуулалт 90%-тай, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийгдэж байна. 2500 хээлтүүлэгч малыг шинжилгээнд хамруулахаар хэрэглэгдэх хэрэглэглэхүүнийг АМЭГ-аас татан аваад байна.

Отор нүүдлийн хяналт:Баруун аймгуудад өвчин гарсантай холбогдуулан мал орох гарах хөдөлгөөн хязгаарлагдсан. Сумаас Булган аймаг руу хуц ухна ачиж явсныг буцааж арга хэмжээг авч ажилласан. Мал эмнэлгийн гэрчилгээнд баталгаажуулалтыг хийсэн. Дорноговь аймаг, Хэнтий аймгийн Гал шар сумаас орж ирсэн 800 гаруй малын эрүүл мэндийн дэвтрийг шалган ажиллаа.

**Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар**